

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА****2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр, Лхагва гараг****Хуралдааны тэмдэглэлийн агуулга****Хуралдааны товч тэмдэглэл:** 1-12**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 13-61

-
- | | |
|--|-------|
| 1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх, үргэлжлэл/ | 14-17 |
| 2.“Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл | 17-34 |
| 3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/ | 34-40 |
| 4.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 40-56 |
| 5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 56-59 |
| 6.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 59-61 |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
04 дүгээр сарын 02-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 86.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 38 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар хэлэлцэх асуудлын дарааллын зургаадугаар асуудал болох бусад буюу “Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаар асуудал болгон хэлэлцэх горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 10
Бүгд: 17
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хоёрдугаар асуудал болгон хэлэлцэхээр тогтов.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Д.Цогтбаатар: 1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт "...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "...шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн "дэмжсэн" санал техникийн саатлын улмаас "эсрэг" гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт "...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ...нас...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс ... нийгэм, хууль зүйн...баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт "...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. "Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилох тухай"
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа, мөн газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Танилцуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Г.Уянгахишиг, Ж.Алдаржавхлан, Ч.Ундром, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Ганбат, Г.Уянгахишиг, Б.Энхбаяр, М.Нарантуяа-Нара, Ч.Ундром, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Ерөнхий сайдаас Улсын Их Хуралд ирүүлсэн Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилуулах тухай саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Да.Цогтбаатар, Б.Пүрэвдорж нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 18 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 88.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын зөвлөх Т.Алтангэрэл, Н.Отгончимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Улсын Их Хурлын даргын зөвлөх Н.Отгончимэг нар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: 1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 11
Бүгд: 18

38.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 9

Бүгд: 18

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргасан боловч Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хоцорч горимын санал гаргасан тухай мэдэгдэж, горимын саналаар санал хураалт явуулаагүй болно.

Д.Цогтбаатар: 2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 18 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 4.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 18 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, шинжээч О.Мандах, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, ахлах мэргэжилтэн Б.Ганзориг, мөн газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга Б.Батдэлгэр, Хэрэг бүртгэх албаны Зөрчлийн хэрэг бүртгэлт, мэргэжил, арга зүйн хэлтсийн дарга Т.Эрдэнэлхагва, Хил хамгаалах ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга О.Сувд-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, П.Сайнзориг, Г.Уянгахишиг нар үг хэлэв.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Д.Цогтбаатар: 1.Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, П.Сайнзориг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 18 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, О.Номинчимэг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 18 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 15
Бүгд: 18
16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, П.Сайнзориг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

9.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 18
Бүгд: 18
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Улсын Ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга Б.Батдэлгэр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга А.Намсаманд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монголын криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг нар оролцов.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Д.Цогтбаатар: Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Наратуяа-Нара Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 59 минут үргэлжилж, 22 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 95.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
15 цаг 38 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Түрүүгийн долоо хоногт хуралдаж байсан хурлаа бид нар ирц хүрэхгүй түр завсарлуулсан байгаа.

Тийм учраас түрүүний долоо хоногийн ирцээрээ энэ хурал маань шууд үргэлжлээд явна. Одоо гишүүд маань бас гүйцэд орж ирээгүй байна. Тэгэхээр Хууль зүйн байнгын хорооны гишүүдийг хуралдаандаа орж ирэхийг бас урьж байна.

Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдөр Хууль зүйн байнгын хороо 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан үргэлжилж байгаа бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг дахин танилцуулъя.

Ирцийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар, Жуковын Алдаржавхлан, Норовын Алтанхуяг, Энхтайваны Бат-Амгалан, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн өмнөх хуралдааны ирцэд бүртгэгдсэн, одоо энэ ирцэд орсон байж байгаа. Гэхдээ чөлөө авсан, хүндэтгэх шалтгаантай чөлөө авсан. Ирцээс хасахыг хүсье.

Дашдондогийн Ганбат гишүүн ирсэн байна. Батжаргалын Заяабал гишүүн ирсэн байна. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн ирсэн байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн байна. Салдангийн Одонтуяа гишүүн ирцэд орсон байгаа. Гэхдээ хүндэтгэх шалтгаантай, гадаад томилолттой. Одоо яг гараад явж байгаа тул ирцээс хасахыг хүсэж байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн ирсэн байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн байна. Даваагийн Цогтбаатар гишүүн ирсэн байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн байна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн ирсэн байна. Одоо ингээд бас ирц дээр нэмж бүртгэгдэх гишүүд байгаа. Тэр нь Ухнаагийн Отгонбаяр гишүүн, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүдийг ирцэд оруулж бүртгэхийг хүсэж байна. Яагаад гэвэл ирчихсэн байж байгаа одоо. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өмнөх хуралдааны бас асуудлууд маань байгаа болохлоор би энэ хэлэлцэх асуудлаа

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

танилцуулагдахъя. Бас өмнөх хуралдааны энэ асуудлуудаа гишүүд маань бас санахгүй байж байж магадгүй. Тийм учраас дахин танилцуулаад явах нь зөв байх. Өмнөх хуралдаан яг санал хураалт дээр зогссон байгаа.

Тийм учраас эхний асуудал бол **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт байгаа. Энэ дээр яг санал хураалтаар асуудал үргэлжилнэ.**

Хоёрдугаар асуудал, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл,

Гуравдугаар асуудал, Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

Дөрөвдүгээр асуудал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл, хэлэлцэх эсэх байгаа.

Энэ гурав дахь асуудал, гуравдугаар асуудал түрүүний дурддаг хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогд холбоотой хуулиудын асуудал бас хэлэлцэх эсэх асуудал байж байгаа.

Тавдугаар асуудал, Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл. Бас хэлэлцэх эсэх байгаа.

Ингээд зургаадугаар асуудал, бусад асуудал гээд төлөвлөсөн байж байгаа.

Энэ хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд нэрсээ өгнө үү.

Даваагийн Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хэлэлцэх асуудлын 6 дахь асуудал болох бусад гэсэн асуудлыг одоо энэ санал хураах процесс явсны дараа урагшлуулж хуралдуулж өгөөч гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Энэ асуудал дээр би бас яг өөрөө горимын ийм саналтай байгаа. Тэгэхээр энэ 6 дахь асуудлыг буюу энэ хэлэлцэх асуудлын 6-д байгаа бусад гэсэн асуудлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдаас 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилуулах тухай саналыг Улсын Их Хуралд ирүүлснийг өнөөдрийн хэлэлцэх асуудлын хоёрдугаарт оруулан хэлэлцэх ийм горимын санал гарч байна. Тэгэхээр энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Тийм хоёрт. Шууд санал хураана.

Энхбаяр гишүүн санал гаргая

Б.Энхбаяр: Уучлаарай эрхэм гишүүд энэ сая бид нар ирцээ орчхоод бараг 2, 3 цаг завсарлаад орж ирээд сая ингээд төхөөрөмж ажиллахгүй байна. Гэрэл нь

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

асаад тэгээд татгалзсан дээр дараад байхад гараад байна. Тийм учраас горимын санал гаргаад саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөч гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Тэгэхээр саяын саналыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

52.9 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүний томъёоллоор энэ зургаадугаар асуудлыг хоёрдугаар асуудал болгон өөрчлөх горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Дараалалд өөрчлөлт орсонд тооцъё. Энэ саналыг дэмжлээ.

52.9 хувиар санал дэмжигдлээ.

Би одоо энд бас гишүүдийнхээ санал хураахын өмнө нэг би та нарт баримт хэлчихье. Энэ ямар үндэслэлтэй юм, энэ зөв юм яваад байгаа байхгүй юу. Жишээлбэл байна шүү дээ АНУ-ын шүүгчдийн дундаж нас 69 байгаа юм. Японых 66 байна, Австралийнх 60 нас, Германых 65, Францынх хамгийн залуу. Гэхдээ дундаж нас нь шүү дээ 50 настай байж байгаа байхгүй юу. Тэгэхээр манайх үнэхээр энэ дээр дэндүү доошоо ингээд тавьчихсан байгаад байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Төрийн албаны хуулиараа 65 нас гэж тавьчихаад зөвхөн шүүх дээр болохлоор 60 гээд ингээд тавьчихсан байгаа чинь өөрөө ялгаварлан гадуурхах нөхцөл байдал үүсгэхээд байгаа нь Үндсэн хуулийн цэцийн яг ялт ч үгүй ийм зөв юу гарчихаад байгаа юм.

Ингээд манайхан энэ дээр анхаарлаа хандуулаарай. Энэ Үндсэн хуулийн хуулийн цэцийн дүгнэлтийг би уншаад танилцуулчихсан байж байгаа. Тэгээд Үндсэн хуулийн хуулийн цэцийн дүгнэлтийг нэг нэгээр нь уншаад явна.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг өмнөх хуралдаанаар хэлэлцэж гишүүд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан бөгөөд одоо шууд санал хураалт явах гэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84.2.2-т Байнгын хороо Цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулах гэж заасны дагуу санал хураалт явуулъя.

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтооно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт шударга ёс, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны Үндсэн хуулийн зарчим мөн гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Пүрэвдорж гишүүнийг бас дэмжсэнээр бүртгэхийг, Алдаржавхлан гишүүн бас. Анхан, Пүрэвдорж гишүүнийг ингээд дэмжсэнээр бүртгээрэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

58.8 хувиар дэмжигдлээ.

Номинчимэг гишүүн бас дэмжсэн байна. Дэмжсэнээр бүртгээрэй.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг насаар нь ялгаварлан гадуурхаж үл болно гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Нара гишүүн дэмжсэн байна. Дэмжсэнээр бүртгэж аваарай.

4.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

64.7 хувиар санал дэмжигдлээ.

5.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатын шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

64.7 хувиар санал дэмжигдлээ.

6.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуульд хууль бүрнээ нийцсэн байвал

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

зохино гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

64.7 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Энэтэй холбогдуулаад би бас ганц зүйлийг хэлээдэхмээр байна. Юу гэвэл ер нь Монголын энэ Төрийн албаны хуульдаа угаасаа 65 гээд заачихсан байхад өөр өөр ийм нас заагаад ороод ирчихсэн хуулийн зөрчлүүд байгаад байгаа шүү.

Тэгэхлээр энэ Үндсэн хуулийн цэцийнхээ дүгнэлтийг дараа нь авч үзээд дахин дахин өөр яагаад байхгүй энийгээ жигдэлж, хэрэглээ, практик дээрээ ч гэсэн ингэж жигдэлж явахгүй бол ийм зөрүүтэй ялгаварласан байдал цаашаа үргэлжлээд байж болохгүй шүү гэдгийг төрийн байгууллагууд бүх шатдаа бас ойлгож, мөрдөж ажиллах ёстой шүү гэдгийг бас тэмдэглэмээр байна.

Энийг бас манай Байнгын хорооныхон ч гэсэн холбогдох байгууллагуудтайгаа энэ хуралдааны мэдээллийг бас зохих ёсоор нь хүргээрэй гэж үүрэг болгож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан гишүүн танилцуулчих уу? Энхбаяр гишүүн өөрөө та яасан юм чинь өөрөө ороод танилцуулчих уу Энхбаяр гишүүн ээ? Тэгвэл Алдаржавхлан гишүүн танилцуулчих тэгэх үү? Тэгье. Зөв зөв.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё.

15.59 цаг

Хоёрдугаар асуудалдаа оръё. Монгол Улсын Ерөнхий сайдаас Улсын Их Хуралд ирүүлсэн Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилуулах тухай саналыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхий сайдаас Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилуулах тухай саналыг 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал танилцуулна.

Учрал сайдын микрофоныг өгье. 5 дугаар микрофон.

Н.Учрал: Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Авлигатай тэмцэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.4-д заасныг тус тус үндэслэн Авлигатай тэмцэх газрын даргаар Зандраагийн Дашдавааг улируулан томилуулах саналыг танилцуулж байна.

Дашдавааг Монгол Улсын Их Хурлын 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Авлигатай тэмцэх газрын даргаар томилсон бөгөөд бүрэн эрхийнхээ хугацаанд хуульд заасан чиг үүргээ хариуцлагатай, шударгаар, үр дүнтэй хэрэгжүүлэн ажилласан.

Дашдаваа нь 1974 онд Хэнтий аймгийн Өндөрхаан хотод төрсөн. 51 настай, яс үндэс Халх, эрэгтэй, дээд боловсролтой, хуульч мэргэжилтэй, хууль зүйн ухааны доктор, Монгол Улсын гавьяат хуульч юм.

Тэрээр 1995 оноос 2019 оныг хүртэл цагдаагийн байгууллагад хэрэг бүртгэгч, эрүүгийн төлөөлөгчөөс эхлээд Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэст тасгийн дарга, хэлтсийн дарга, Цагдаагийн ерөнхий газрын дэд даргаар дэвшин ажиллаж улмаар 2019 онд Авлигатай тэмцэх газрын даргаар томилогдсон.

Тэргүүн комиссар Дашдаваа нь цагдаагийн байгууллагад 24 жил, Авлигатай тэмцэх газарт 6 дахь жилдээ, хууль сахиулах байгууллагад 30 дахь жилдээ ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газрын дарга Дашдаваа нь тус газрын даргаар томилогдон ажиллах хугацаандаа Хөгжлийн банк, Эрдэнэт үйлдвэрийн 49 хувь, Хөтөлийн Цемент Шохой, Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийн хувьчлал, Оюутолгойн, Дубайн гэрээ, Боловсролын зээлийн сан, нүүрсний, ногоон автобусны зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд холбогдсон Улсын аюулгүй байдал, эдийн засагт сөрөг үр дагавар бүхий их наядаар хэмжигдэх хохиролтой авлигын хэргүүдийг богино хугацаанд шалган тогтоох ажлыг удирдан хууль сахиулах байгууллагуудтай хамтран хянан шийдвэрлээд байна.

Тухайлбал, Хөгжлийн банкны хэвийн үйл ажиллагаа алдагдаж, дампуурал зарлахад туссан хүнд үед тухайн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааг шуурхай, эрчимтэй зохион байгуулснаар хохирол нөхөн төлүүлэх арга хэмжээний үр дүнд нийт 1.6 их наяд төгрөгийн хохирлыг нөхөн барагдуулж, Хөгжлийн банкны 500 сая ам.доллар-ын бондын өр, Самуурай бондын 30 гаруй тэрбум иений зээл эргэн төлөгдөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Дашдаваа даргатай Авлигатай тэмцэх газар нь өнгөрсөн хугацаанд авлигын гэмт хэргийн улмаас төрд учирсан хохирол, нөхөн төлөлтийн чиглэлд анхаарч ажилласан бөгөөд 2007 онд 5.3 сая төгрөгийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөгдөж байсан бол 2022 онд 2.3 их наяд, 2023 онд 238.6 тэрбум, 2024 онд 240.9 тэрбум төгрөгийн хохирлыг хохирлыг нөхөн төлүүлж улсын төсөвт төвлөрүүлжээ.

Түүнчлэн олон улсын байгууллагатай хамтран ажиллах хамтын ажиллагааны хүрээнд Ази, Номхон далайн орнуудын хууль сахиулах байгууллагуудын сүлжээ байгуулах эхлэлийг тавьж, хөрөнгө буцаах байгууллага хоорондын авлигын эсрэг сүлжээний харилцаа, хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлэн батжуулахад үнэтэй хувь нэмрээ оруулан ажиллажээ.

Гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллага олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, гадаад улсад байгаа гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

битүүмжлэх, хураан авах, хөрөнгө буцаан авах үйл ажиллагааны хүрээнд 2021-2024 онд нийт 13.9 сая ам.доллар-ын үнэ бүхий хулгайлагдсан хөрөнгийг гадаад улсаас буцаан авчирч, улсын орлого болгосон байна.

Мөн хуулийн дагуу хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нийтийн албан тушаалтан өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдох орлогоо үнэн зөв мэдүүлээгүй нөхцөл байдлыг шалган 2023 онд 8.3 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 637 сая төгрөг, 2024 онд 2.1 тэрбум төгрөгийн зөрчилд 136.4 сая төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги ноогдуулж барагдуулсан байна.

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхэд залуучуудад шударга ёсны үнэ цэн, үнэт зүйлийг ойлгуулах, зөв хүмүүжил, дадлын бий болгоход туслах, авлигыг үл тэвчих үзэл санааг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг өргөн хүрээнд тодорхой бүлгийн онцлогийг харгалзан зохион байгуулсан нь зохих үр дүнд хүрч, үнэлгээгээр хүүхэд залуучуудын шударга байдлын түвшин 0.8 функтээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Их Хурлаас 2016 онд баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2016-2020 он хүртэл, 23 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг хариуцаж, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг төлөвлөгөөний хамтаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар Авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулах зорилтын хэрэгжилтийг хангах, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх. Түүнчлэн 2028 онд ДНБ-ийг 132.3 их наяд төгрөгт, 1 хүнд ноогдох ДНБ-ий одоогийн ханшаар 10 мянган ам.доллар-т хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд авлигын эрсдэлгүй байж, эдийн засгийн өсөлтийг дэмжих нь нэн тэргүүний шаардлага, хэрэгцээ болоод байна.

Иймд Дашдаваа нь улс төр, бизнесийн бүлэглэлийн нөлөөллөөс ангид, хууль шударга, ёсны зарчмыг дээдэлж, хүний эрхийг хангаж, хуулиар хүлээсэн чиг үүргээ чин шударгаар, нэр төртэй биелүүлж ирснийг онцлон Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-д заасныг баримтлан Авлигатай тэмцэх газрын даргын албан тушаалд улируулан томилуулах саналтай байна.

Авлигатай тэмцэх газрын дарга тэргүүн комиссар Зандараагийн Дашдавааг тус газрын даргын албан тушаалд улируулан томилуулах асуудлыг хэлэлцэн дэмжин шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Учрал сайдад баярлалаа. Одоо ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Монгол Улсын сайд Учрал, Авлигатай тэмцэх газрын дарга, Тэргүүн комиссар Дашдаваа, Авлигатай тэмцэх

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Баасанням гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хуралдаанд оролцож байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү.

Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Нэр дэвшигч дэвшигчээс тодорхой асуулт асууя. Сая таны танилцуулгад энэ микрофон яачхаад байгаа юм сонин ийм пүг үг гээд сонсогдохгүй байх юм. Харин тийм.

Энэ танилцуулга чинь Эрдэнэт үйлдвэрийн 49 хувь, Дубайн гэрээ эд нар гээд ингээд асуудлууд дээр сайн ажилласан гэж ярьж байна. Тэгээд энэ хэргүүдтэй холбоотой холбогдогч нар ер нь ямар хариуцлага хүлээсэн бэ? Тэгээд гадагшаа гараад зугтчихдаг, энэ араас нь олж ирэх, хариуцлагыг нь хүлээлгэх энэ асуудал дээр Авлигатай тэмцэх газар хэрхэн, яаж бусад Тагнуулын газартай ч гэдэг юм уу, цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллаж байна вэ? Сүүлийн үед ингээд хараад байхад ер нь томоохон нөхдүүдийн холбогдсон хэргүүд асуудал үүсээд шалгаж байгаа боловч шалгаж байгаа хугацаандаа гадагшаа гараад зугтдаг ийм моод болоод байна шүү дээ. Тэгээд араас нь хөөцөлдөх ч юм уу, үгүй ч юм уу? Гаднаас ингээд элдэв янзын сошиалаар янз бүрийн юм яриад байгаа улсууд зөндөө л байгаа шүү дээ. Тэгээд бид нар ингээд Засгийн газар өнгөрсөн 4 жилд “5 Ш” ажиллагаа гээд л хийсэн, шүүр ажиллагаагаар хэчнээн өндөр албан тушаалтнуудыг олж ирсэн, хариуцлага хүлээлгэсэн энэ дээр ямар ахиц, өөрчлөлт гарч байгаа юм бэ? Цаашдаа энэ дээр энэ Эрдэнэт үйлдвэрийн 49 хувь, Дубайн гэрээний асуудалтай холбогдуулсан энэ хэргүүд дээр энэ холбогдож байгаа төрийн өндөр албан тушаалтнууд холбогдсон улсуудад олж ирэх асуудлыг яаж хэрхэн шийдэх юм? Энэ асуудлууд эцэслэн шийдэгдээгүй байгаа гэж би хувьдаа ойлгож байгаа.

Яагаад гэхээр холбогдсон улсууд нь хариуцлага хүлээхээс мултраад гадагшаа улс орон руу оргон зайлсан учраас. Тэгэхээр энэ эцэслэн шийдэгдээгүй гэж ойлгож байгаа. Тэгээд энэ дээр бас та хариулт өгөөч гэж.

6 дугаар микрофон Дашдаваа даргын микрофоныг өгье.

3.Дашдаваа: Эрхэм Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Хэргүүд процессынхоо дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдэх тухай хуулийн дагуу шалгагдаад зарим хэргүүд нь прокурорын байгууллагаас шүүхэд шилжсэн. Шүүх дээрээ зарим асуудлууд бий.

Ингээд Монгол Улс өнөөдөр эрүүгийн харилцан туслалцах гэрээгээрээ 20 орчим оронтой, иргэний харилцан туслалцах гэрээгээр 16, 17 орчим оронтой ийм харилцан туслалцах ийм эрх зүйн ийм гэрээнүүд байдаг юм билээ.

Манай байгууллагын хувьд бид НҮБ-ын конвенцоо бариад уул нь 180 орчим орон, 83 орчим орон конвенц нэгдэн орсон байдаг. Конвенцынхоо хүрээнд бид харилцан мэдээлэл солилцоод явдаг.

Энэ нэр бүхий, энэ гадаадад оргон зайлсан хүмүүсийг бид өнгөрсөн жил Монгол Улсын Засгийн газартай хамтран Шувуу, Шүгэл гэх мэт ийм олны бас анхааралд оруулж ийм арга хэмжээ зохион байгуулсныхаа үр дүнд тодорхой хүмүүсийг авчирсан. Нэр бүхий хүмүүсийн гадагшаа оргон зайлсан асуудал нь өөрөө энэ таслан сэргийлэх арга хэмжээ зөрчиж ийм таслан сэргийлэх арга хэмжээ бол яг хуулийн дагуу зөрчөөгүй, тодорхой холбогдох байгууллагад нь хүсэлт тавиад ингээд журмынх нь дагуу асуудлаа шийдээд тэгээд эргэж ирээгүй л ийм асуудлууд байгаа юм. Гол нь яг ингээд таслан сэргийлэх арга хэмжээг зөрчөөд, тэгээд хэлээр хууль бусаар гараад ингээд явчихсан асуудал Монгол Улсад байхгүй. Яг өмгөөлөгчөөрөө дамжуулдаг юм уу яг Эрүүгийн хэрэг хянан шийдэх тухай хуулийн хүрээнд энэ хүсэлтээ тавиад шийдүүлдэг газраар нь шийдүүлдэг хууль, эрх зүйн дагуу тэгээд гарч явчхаад ингээд яг ирэх хугацаандаа ирээгүй ийм л асуудлууд байгаа юм.

Тэгээд бид нар эдгээр албан тушаалтнуудыг олж ирэх чиглэлээр бас тухайн хамааралтай байгууллагууд болон бусад цагдаагийн байгууллага, интерпол, бусад тухайн орны хууль сахиулах байгууллагуудтай бас мэдээлэл солилцоод хамтран ажиллаж байна. Ингээд тодорхой хэмжээгээр шүүх дээр энэ тухайн асуудлууд тусгаарлагдаад Үндсэн хуулийн хэргүүд шийдэх шинжтэй явж байгаа. 49 хэрэг ч гэсэн өнөөдөр тодорхой бас хүмүүс нь байхгүй боловч тусгаарлаад шийдэх боломжтой гээд Улсын дээд шүүхээс анхан шатны шүүх рүү шилжүүлсэн байгаа. Ингээд ойрын хугацаанд шүүх хурлууд нь явагдаад ингээд шийдвэрлэх бүрэн боломжтой гэж ойлгож байгаа. Баярлалаа танд.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Одоо Авлигатай тэмцэх газрын дарга маань яг 6 жил ямар ч байсан ажил үүргээ гүйцэтгээд дахин томилогдохоор орж ирж байна.

Тэгэхээр яг энэ хугацаанд хийсэн ажлууд дээр гарсан үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ гэж байгаа болов уу? Тэр гүйцэтгэлийн үнэлгээтэй танилцах боломж байна уу? Мөн түүнчлэн авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2023-2030 оны хөтөлбөр байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд 23, 24 онд яг ямар ажлууд хийгдсэн байгаа вэ гэдэг дээр бас мэдээлэл байгаа болов уу?

3 дахь асуулт болохоороо энэ Үндсэн хуулийн хөтөлбөр дээр тусгагдсан зорилгуудын 3 дугаар зорилго байгаа. Биш ээ 5 дугаар зорилго. Энэ 5 дугаар зорилго дээр бол гол нь Авлигатай тэмцэх газрын хараат бус байдал сайжруулах, мөн түүнчлэн нөлөөллийн эрсдэлийг бууруулна гэдэг зорилго байгаад байгаа юм. Тэгэхээр би бас зөвлөлийн хурал дээр бас асуусан асуулт юу вэ гэхээр өнөөдөр бид нар нөлөөллийн эрсдэлээ бууруулна гэж байгаа юм бол тухайн нөлөөллүүд нь яг ямар ямар нөлөөллүүд байдаг юм? Тэр нь өөрөө эрсдэлийн хувьд яаж үнэлэгдэж байгаа юм, хамгийн эрсдэл өндөртэй нь байгаа юм, шийдэж болох нь юм, шийдэхийн тулд төвөгшилтэй нь юм гэдэг энэ жагсаалтуудаа гаргаж харсан юм болов уу?

Нөгөө талаасаа дотооддоо хийх зохион байгуулалтуудаа буюу хараат бус байхын тулд цалин, хангамж ч гэдэг юм уу, ажлын нөхцөл байдал гэдэг юм уу тэр талаасаа хангаад, зохицуулаад боллоо гэхэд хөндлөнгийн нөлөөлөл буюу улс төрчдөөс очих нөлөөлөл, тэр хөндлөнгийн нөлөөллүүдээ үнэлсэн үнэлгээ байна

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

уу? Тэрийг бууруулахын тулд жишээлбэл эрх зүйн зохицуулалтууд дээр ямар шинэчлэл хийх хэрэгтэй байна, ямар хамгаалалтын хэрэгслүүд хэрэгтэй байна гэдэг дээр бас саналуудыг нь сонсмоор байна.

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон өгье.

3.Дашдаваа: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. 6 жилийн үйл ажиллагааны, 6 жил ажиллахдаа жил болгон манай байгууллага стратеги төлөвлөгөө гаргаад төлөвлөгөөний дагуу биелэлтээ хангаад явдаг. Энэ авлигын нөхцөл байдлын талаар мэдээллийг Хууль зүйн байнгын хороо болон Улсын Их Хуралд жил бүр хүргүүлдэг. Мөн Хууль зүйн байнгын хороонд хяналт шалгалтын чиглэлийн ХОМ-ын мэдээллүүдийг 2 сарын 15-наас хойш мэдээллүүдийг хүргүүлээд ингээд явдаг. Яг одоо Авлигатай тэмцэх газрын даргыг тэгж үнэлнэ, энд ингэж үнэлнэ гэсэн ийм энэ хуулиараа энэ ийм зохицуулалт одоогоор байхгүй.

Ямар ч байсан бид 6 жилд, урьд нь 16-2023 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 75.6 хувьтай дүгнээд Улсын Их Хурлаар оруулаад явсан байгаа. Энэ чинь 2023 онд.

Шинэ үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө гарчихсан явж байгаа. Төлөвлөгөө дээр саяын яриад байгаа нөлөөллийн асуудлыг бид энэ юунд оруулчихсан юм байна. Энэ чинь хэддүгээр асуудал билээ? 5 дугаар асуудал дээр бид нар 4.1 дээр 30 он хүртэл энийг ямар ч байсан тодорхойлно гэсэн. Яг өнөөдөр манайхаас яг ингээд нөлөөллийг, хуулиараа хамгаалалтуудыг хийж тавигдсан боловч нөлөөллийн асуудлуудыг ямар нэгэн байдлаар одоогоор ямар нэгэн байгууллагаар үнэлүүлсэн ийм асуудлууд байхгүй байна.

Дотооддоо бид нар тэрийгээ хэлж яриад ингээд ямар нэгэн хэрэг мөрдөн байцаах ажиллагаанд гаднаас хүн нөлөөллөө гэхэд нөлөөллийн хуудсаа бичиж байгаа. Ямар ч гэсэн тэрийгээ мөрдөгч нар, бүх мөрдөгч нар бичдэг. Энэ хэрэгт өөрөө нөлөөтэй бол тэрийгээ өөрөө бичээд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд татгалздаг. Дарга нь бас тэрнээс татгалзаад явдаг иймэрхүү юмнууд үйл ажиллагаанд хэвийн хэвшсэн, тогтсон юмнууд бий.

Д.Цогтбаатар: Нэмж асуух уу? Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Зүгээр саяын үнэлгээний асуудал яригддаг нь бол мэдээж өмнө нь яг байгууллагын гүйцэтгэл ч гэдэг юм уу, байгууллагын хийсэн ажил тодорхой гарч ирж байгаа байх л даа. Тэгэхдээ аливаа албан тушаалд ч гэдэг юм уу, томилогдох гэж байгаа тохиолдолд яг тэр дан ялангуяа дахин томилогдох гэж байгаа тохиолдолд өмнөх ажлын үнэлгээг уг нь тусад нь бас гаргаад танилцуулдаг байвал бас зүгээр юм болов уу гэж бодож байгаа юм. Тэрнээс бид нар ерөнхийдөө яг ерөнхий юм яриад байдаг. Гэтэл яг энэ дарга ажлыг хүлээж авснаасаа хойш тэгээд яг энэ ажлуудаа ингээд хийчихсэн байна.

Жишээлбэл, 23 оны хүртэлх үндэсний хөтөлбөрөөс гол гол ажлууд энийгээ бол энэ хугацаанд хийчихсэн байна 19 оноос хойш, 23-аас хойш бол 25 он хүртэл энэ хөтөлбөрөөсөө энэ энэ ажлуудаа хийчихжээ гээд ингээд харахад ойлгомжтой байх юм бол бас буцаагаад тухайн албан тушаалтныг томилоход бас ер нь ойлгомжтой байдал байх болов уу л гэж бодож байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Д.Цогтбаатар: Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

Ж.Алдаржавхлан: Дашдаваа даргыг дэмжиж байгаа. 2 зүйлийг ер нь асуух гэсэн юм гэж.

Нэгдүгээрт, сая манай Сандаг-Очир гишүүн хөндчихлөө дөө. Тэр Сайханбилиг гээд хүн Америкийн Нэгдсэн Улсад оччихсон байж байгаа. Тэрийг ер нь ойрын ирээдүйд бид нарт авчрах боломж байна уу, үгүй юү гэдгийг та бас Их Хурлын гишүүдэд бодитойгоор нэгд хэлж өгөөч. Тэгээд тэр хүн ирэхгүй болохлоор бусад нь ингэж болдог юм байна, гадаадад очоод ингээд байгаад ирэх юм, болох юм байна гэсэн ойлголт Монголын нийгэмд их хүчтэй түгсэн байна.

Хоёрдугаарт нь та сонгогдоод ирэх 6 жил энэ тэр соён гэгээрүүлэх чиглэлээр нэлээн хүчтэй ажил хийвэл яасан юм бэ гэсэн зүгээр миний хувийн бодол байдаг юм. Жишээ нь бид нарт ийм манай Монголд ийм авлига ч юм шиг, өглөг ч юм шиг юмнууд зөндөө байгаа юм. Хагалгаанд орохоор л эмч нарт нь хэдэн төгрөг заавал барьдаг, хүүхэд төрүүлэхээр ч тэрийг барьдаг, нөгөөдүүл нь ч авч байдаг ийм сонин авлига гэхэд хэцүү, өглөг гэхэд хэцүү ийм зүйлүүд олон байгаа юм. Тэгэхээр энийг бас сэтгэлгээний хувьд өөрчилж ирэх жилүүдэд энэ соён гэгээрүүлэх чиглэлээр бас тодорхой ажлуудыг хийх ямар төлөвлөгөө байна гэсэн ийм 2 асуулт байна.

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон.

З.Дашдаваа: Сая тухайлсан хүний нэр асууж байх шиг байна. Ер нь АНУ-тай эрх зүйн харилцан туслалцах гэрээ байхгүй. Энэ бол тодорхой хэмжээгээр бас их өөрөө л ирэхгүй бол манай байгууллагын зүгээс болон манай хууль хүчний байгууллагын зүгээс бас тэн дээр арга хэмжээ авах ер нь бололцоо муутай байгаа.

Соён гэгээрүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх чиглэлийн ажил бол манай байгууллагын тэргүүний зорилтот ажил. Ер нь гол ажлын нэг. Бид соён гэгээрүүлэх чиглэлээр боловсролын байгууллагатай нэлээн бас хамтын ажиллагаа авлигыг үл тэвчсэн болон үл тэвчих ийм үзэл залуучууд, хүүхдүүдэд хүргэх чиглэлээр боловсролын байгууллагуудтай, сургуулиудтай бас хамтран ажиллаж байна. Бүх сургуулиудын ихэнх чадвал бүх сургуулиуд ерөнхийдөө энэ сургуулиудад шударга ёсны кабинетыг бид нар байгуулж байгаа. Ингээд байгуулаад явж байна. Ямар ч гэсэн энэ төсөв мөнгөний хүрэлцээтэй байвал бүх сургуулиуд шударга ёсны кабинеттай, шударга ёсны бүлэгтэй энэ чиглэлийн сургалт ордог ийм чиглэлээр явахыг зорьж байгаа.

Боловсролын яамтай, сайдтай бид сургалтын хөтөлбөрт, үндэсний хөтөлбөрт заачихсан байгаа сургалтын хөтөлбөрт энэ авлигыг үл тэвчих үзлийг бий болгох чиглэлээр энэ сургалтын хичээл ордог болъё гэсэн ийм зорилт тавиад явж байна.

Д.Цогтбаатар: Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Тийм. Тэгээд би соён гэгээрүүлэх чиглэлээр ажиллаасай гэдгийгээ л нэлээд тийм дэмжиж байгаа. Түрүүний миний яриад байсан жишээ бол бид нар бүгдээрээ хүлээн зөвшөөрчихсөн тийм нэг юм байгаа шүү дээ эрүүл мэндийн салбарын жишээ нь. Тэгэхээр тэрийг заавал хүн амьтныг шалгаж,

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

цагдахгүйгээр соён гэгээрүүлэх ирэх жилүүдэд бас болох юм байна л гэсэн надад хувийн бодол байдаг юм. Тийм арга хэмжээ зохион байгуулаад ингэж болохгүй шүү гэдэг юм уу, ямар нэгэн хэлбэр бид нар тийм юмнаас салах ёстой л байгаа Монголчууд бид нар. Тийм хүнд юм өгдөг. Нөгөөдөх нь аваад орчихсон тэр сэтгэлгээнээс бид нар салахгүй болохлоор л Монголын нийгэмд энэ авлигын асуудал ингээд жижиг жижгээрээ энд тэнд л ингээд л олноор байгаад байгаа. Тийм учраас ирэх 6 жилээс таныг бас энэ соён гэгээрүүлэх чиглэлээр бас хүчтэй ажиллаасай гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Ундрaм гишүүний микрофоныг өгье.

Ч.Ундрaм: 6 жил Монгол Улсын авлигатай тэмцэх ажлыг хариуцаж байсан хүн дахиад 6 жил ажиллах гээд нэр дэвшээд орж ирж байгаа энэ хүнээс Авлигын төсөөллийн индексийг асуухгүй байхын аргагүй. Манай Монгол Улс өнгөрсөн жил Авлигын төсөөллийн индексээр 100 онооноос 30 оноо авсан. 30 авна гэдэг чинь муугийн муугийн муу гэсэн үг. Ард түмэн танд ийм дүн тавьсан байна. Манай улс Авлигын эсрэг конвенцод нэгдэж ороод энэ “Трансперенси интернэйшнл” гэдэг байгууллагыг хүлээн зөвшөөрөөд, энэ байгууллагаар судалгаагаа хийлгээд, тэндээс экспертүүд нь ирээд жил болгон энэ судалгаагаа хийдэг. Энэ байгууллагын олон улсын хуралд танайхаас хүмүүс жил болгон очиж оролцдог. Тэгээд энд бид нар 130 гаруй орноос 121-д ингээд орчихсон явж байгаа. Бид нартай зэрэгцээд урд, хойно ойрхон Хойд Солонгос гээд ийм авторитар дэглэмтэй улс орнууд, иргэний дайнтай улс орнууд ингээд явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ авлигын төсөөллийн индексийг та хүлээн зөвшөөрөх үү? Тодорхой хэмжээгээр таны хийсэн ажилд ард түмэн дүн тавьж байна гэж ойлгож болох уу гэдэг нэг асуулт.

Хоёрдугаарт ирж байгаа гомдол бол нэлээд өссөн 1863 болсон гээд тэгж байгаа юм. Тэгээд эндээс яг хэдэн хувь нь, хувь гэж байгаа шүү би тоо биш. Хувь нь шийдэгдсэн байна вэ энэ 2024 он гэхэд? Бид нар хувиар л яг шийдэгдсэн хэргийн хувиар л ажлын үзүүлэлтийг чинь харна шүү дээ. Тэгээд нийгмийн олон нийтийн анхааралд орсон хэдэн хэргийг нь маш хурдан шийдчихдэг. Анхааралд орохгүй болохоор нь шийдэхгүй удаагаад ингээд яваад байдаг. Зарим хэрэг чинь бүр ингээд та хэд янз бүрийн шалтаг шалтгаан гаргаад 2, 3 жил гацааж байгаа хэргүүд байгаа шүү дээ. Маш олон байгаа.

Дараагийн асуулт энэ 1863 хэрэг дотор чинь эмч, багш нартай холбоотой яг хэдэн асуудал байдаг юм? Бусад албан тушаалтны хэрэг, яг төрийн албан тушаалтны хэрэг нь хэдэн хувь байдаг юм? Компанийн албан тушаалтны хэрэг нь хэдэн хувь байдаг юм? Яг тэр хувийг нь бас сонсож, мэдэж авмаар байна.

Боловсролын зээлийн сангийн маш олон хүмүүс энэтэй холбогдсон шүү дээ. Энэ яг хэдэн хэргийг нь та хэд шүүхэд шилжүүлсэн юм? Хэдээс хэдийг шалгаад хэрэг үүсгээд яг хэдийг нь шүүхэд шилжүүлсэн юм бэ гэсэн тоог мэдмээр байна.

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон өгье.

3.Дашдаваа: Ундрaм гишүүний асуултад хариулъя. Ти Ай-ийн гаргаж байгаа төсөөллийн индекс манай улс орон, улс 180 орноос 114 дүгээр байранд 33 хувьтай явж байгаа. Анх энэ 2000 оноос төсөөллийн энэ нийтдээ 13 индикатор ер нь сүүлийн үед 9 индикатор байгууллага энэ үнэлгээ өгдөг болсон. Энэ дээр

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ерөнхийдөө төсөөллийн индекс бол нийтдээ 180 орноос 101 оронд сүүлийн 12 жил 101 орноор хөдөлгөөнгүй байгаад байгаа юм. Нийтдээ 79 орны төсөөллийн индекс нааш цаашаа хөдөлж байгаа. Энэ хөдөлж байгаа орон дотор, энэ юун дотор бол манай улс орон орж явдаг.

Төсөөллийн индекс маань юуг илэрхийлээд байдаг юм бэ гэхээр, юу гэж бидэнд зөвлөөд байдаг юм бэ гэхээр 4, 5 зөвлөмжүүд тогтмол өгдөг юм. Манайх ер нь 39-өөс 33 оноотой явж байгаа. 39 байсан. Энэ дээр анхаарах вэ гэвэл бидэнд юу анхаараад та нар энийг хэрэгжүүлээч, ингэвэл танай улс авлига тодорхой хэмжээгээр буурах гээд байна гэдэг зөвлөмжүүдийг өгдөг. Энэ дээр нэгдүгээрт юуны хууль, Шүгэл үлээгчийн хуулиа батлаач.

Хоёрдугаарт, намынхаа санхүүжилтийг шилэн болгооч.

Гуравдугаарт, ТӨК-удынхаа засаглалыг сайжруулаач.

Дөрөвдүгээрт, энэ худалдан авах ажиллагааныхаа чиглэлээр хууль, дүрмээ бас янзлаач гэсэн энэ асуудлуудыг бидэнд зөвлөдөг. Энэ зөвлөмжийн хүрээнд бид нар тодорхой хэмжээгээр авлигатай тэмцэх байгууллага энэ дээр рольтой ажиллах ёстой гэдэг утгаараа бид нар энэ үндэсний хөтөлбөрт, 23 оны үндэсний хөтөлбөрт оруулаад ингээд батлаад хэрэгжүүлээд явж байна. Зөвхөн ингээд авлигатай тэмцэх байгууллагын ажлыг авлигын төсөөллийн индексээс үнэлэхээс, төсөөллийн индекс үнэлэхээс гадна энэ бол манай улс орныг үнэлж байгаа асуудал. Бид энэ засгаас гарч байгаа шийдвэрүүд, Улсын Их Хуралд гарч байгаа хууль тогтоомжууд энд бүгд энд төсөөллийн индекс хамаарч байгаа. Бид улс орон даяараа л өнөөдөр нийтээр хэрэг төвөг, олны анхаарал татсан хэргүүдийг ярьж хөөрч байгаа учраас бол төсөөллийн индекс тэнд нөлөөлж байгаа гэж бид харж байгаа.

Мөн энэ Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг 2023 онд НҮБ-ын Авлигын конвенцын зүгээс ирж дүгнэсэн 2, 5 дугаар бүлгийг. 5 дугаар бүлэг нь хөрөнгө буцаах, 2 дугаар бүлэг нь урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр. Энэ дээр Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын байгууллагын үйл ажиллагаа бас хэвийн, ахицтай явж байна гэсэн бас ийм үнэлгээ өгөөд явсан байна. Мөн Европын эдийн засгийн аюулгүй байдлын “Өү Си Ди” гэж байгууллагад манайх 16 орны нэгт ингэж хамрагдаж тайлан, мэдээлэл гаргаж явдаг. Энэ байгууллагын зүгээс бас биднийг бас тодорхой хэмжээгээр бас авлигатай тэмцэх үйл ажиллагаа тодорхой хэмжээнд бас хэвийн явж байна гэдэг ийм бас ийм үнэлгээ өгсөн байгаа.

Дараагийнх нь юу билээ? Боловсролын зээлийн сан дээр нийтдээ хэрэг бүртгэлтийн 8 хэрэг, мөрдөн байцаалтын 2 хэрэг явж байна. Шүүхэд 1 хэрэг шилжүүлчихсэн явж байна. Эндээс өнгөрсөн онд 590 сая төгрөгийн хохирлыг боловсролын зээлийн талд нөхөн төлүүлсэн ийм байдалтай байна. Энэ.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофоныг гүйцээгээд өгье.

3.Дашдаваа: Нийт ирсэн өргөдөл, гомдлын 98 хувийг бид нар шийдвэрлэсэн байна. Энэ яаж шийдвэрлэх вэ гэхээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээх юм уу, эсвэл хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэхээс татгалзах саналыг прокурорт гаргасан байна гэсэн үг.

Энэ ангиллаар нь үзвэл төрийн үйлчилгээний байгууллагын албан тушаалтан гэдэг ангиллын албан тушаалтан бол 14 хувийг нь эзэлж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ундрам гишүүний микрофоныг өгье. Тодруулъя.

Ч.Ундрам: Боловсролын зээлийн сангийн хэрэг шалгагдаж эхлээд 2, 3 жил болж байна шүү дээ. Та тэгэхээр яг 10 хэрэг нь шийдэгдээгүй танай дээр явж байна, 8, 2 гээд хэлж байна.

Хорьдугаарт, нийт гарсан гомдлын 98 хувийг нь та хэд шийдвэрлэчихсэн юм байна тээ? Тэгэхээр ард иргэд энийг сонсож байгаа шүү дээ. Авлигатай тэмцэх газар өгсөн гомдлын 98 хувь шийдвэрлэгдчихсэн. Энэ чинь одоо маш сайн үзүүлэлт харагдаж байгаа байхгүй юу.

Гэтэл ийм өндөр шийдвэрлэгдсэн хувьтай байхад Авлигын төсөөллийн индексээр та хэдэд 30 оноо өгөөд байна. Яг одоо та “Трансперенси интернэйшнал” гээд байгууллагын веб сайтад ороод үз 30 оноо гэхихсэн байгаа шүү. 38 ч биш, 9 ч биш 30. 121 дүгээрт байгаа шүү. Та яг одоо веб сайтаар нь би яг саяхан орж үзээд шалгалаа. Тэгээд гол асууж байгаа асуулт нь авлигын хэрэгт холбогд.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон.

З.Дашдаваа: Ундрам гишүүний асуултад хариулъя. Яг ингээд авлигын төсөөллийн индексийг яг та авлигатай тэмцэх байгууллагын яг 100 хувь үнэлгээ гэж бас ойлгоод байх шиг байна л даа. Гэхдээ энэ яах вэ бид ямар нэгэн байдлаар хариуцлагаас зугтаж байгаа юм биш. Энэ төсөөллийн индекс гэдэг маань энэ өнөөдөр манай улс орон, төр засаг маань ямар байгааг л үнэлж байгаа. Иргэд маань ямар үнэлгээ өгөөд байгааг л энэ хэлж байгаа энэ үнэлгээ шүү дээ.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Би 2 юм асуучихъя гэж бодож байна.

Энэ танай байгууллагын ажилтай Байнгын хороогоор очоод танилцаж байхад яасан авлигын, ер нь учир шалтгааны талаар бид нар ярилцаж байсан. Тэгэхэд төрийн өмчит аж ахуйн нэгжүүд төсвийн асуудал энэ бол энэ ялангуяа төрийн өмчит аж ахуйн нэгжүүд их томроод байгаа, төсөв энэ томроод байгаа бас өөрөө учир шалтгаан нь болж байгаа гэдэг юмыг та нар ярьж байсан. Тэгээд миний яг одоо тухайн үедээ ингээд өргөн бариад хөөцөлдөөд явж байсан төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг нэгээр ч нэмэхгүй гэсэн тогтоолын төсөлтэй яг үзэл санаа нэгтэй байсан учраас би тухайн үедээ та бүгд дээр яг энэ ажлаараа та нар засагтайгаа нэлээн ажиллаад, энэ бас миний тогтоолыг дэмжээд саналаа наад дээрээ өгөөдхөөрэй гээд тэгж байсан. Ер нь та нар мэдээж санал гаргаад л өгч байгаа байх. Тэгээд засаг төр маань ер нь хэр сонсож байна даа? Та нарын жишээлбэл ингэж өгч байгаа.

Яагаад гэвэл энэ учир шалтгааныг нь арилгаагүй байхад энийг даван туулж шийдэх маш хэцүү. Тийм учраас та нар ингээд саналуудаа өгч байхад Засгаас энэ дээр хэр хүлээцтэй хандаж байна? Нэг дэх асуулт.

Хоёр дахь асуудал нь яг энэнтэйгээ холбоотой. Та нар ийм судалгаа хийж үзсэн үү? Яг төсөв нэмэгдэж байгаа тэр динамик, мөн түүнчлэн төрийн албан хаагчдын тоо нэмэгдэж байгаа динамик, авлигын хэрэг бүртгэгдэж байгаа энэ тоотой хэр уялдаатай байна вэ? Өөрөөр хэлбэл, энэ учир шалтгаан нь өөрөө төрдөө, төр нь өөрөө томроод томроод яваад байгаа болохлоор энэ 100 хэдэн мянган их мөнгөтэй харьцаж байгаа хүний энэ үйлдлийг чинь хянах та нарт угаасаа л хэцүү болно шүү дээ. Тэгэхээр энэ хоорондын харилцааг та нар судалж үзсэн үү? Ийм 2 асуулт байна.

6 дугаар микрофон.

З.Дашдаваа: Бид олон улсын байгууллагууд болон энэ Ти Ай-ийн гаргасан энэ зөвлөмжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газарт, гүйцэтгэх засаглалд зөвлөмж хүргүүлдэг. Одоо энд олон улсын байгууллагын судалгаа шинжилгээгээр ийм байр багцаатай байна, энэ дээр та бүхэн ийм ажлууд хэрэгжүүлж ажиллаач, энийг зөвлөж байна гэдэг асуудлуудыг бид тавьдаг. Үүний дагуу үндэсний хөтөлбөрийг өнөөдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга ахалж байгаа. Үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ахлаад бүх гүйцэтгэх засаглалын яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар байгуулагдсан Үндэсний хороо байгуулагдсан явж байгаа. Тэгэхээр энэ Үндэсний хороо бол манай байгууллагаас өгч байгаа зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана гэж итгэлтэй байгаа.

Төсөв нэмэгдэж байгаа тэгээд энэ авлигын гэмт хэрэгтэй холбоотой уялдаж байна уу гэдэг энэ судалгааг манай судалгаа, шинжилгээний алба нэлээн сайн хийж байгаа юм. Энэ дээр бид нар юун дээр анзаараад байдаг вэ гэвэл өнөөдөр бидэнд ганц өгөөд байгаа коммент бол төрийн өмчийн компаниуд чинь нэмэгдээд байна. Энэ чинь ингээд хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд байна. Тэгээд засаглал нь энэ тунгалаг биш байна гэдэг л асуудлууд яригдаад байгаа юм.

Тэгэхээр энэ төрийн өмчийн компанийн албан тушаалтнууд чинь нийтийн албан тушаалтныхаа зарим ангилалд нь зарим нь ордоггүй, зарим нь удирдах ажилтнууд нь ороод зарим нь ордоггүй ингээд нийтдээ энэ 45 мянган хэдийгээр нийтийн албан тушаалтан байгаа ч, ингээд нийтийн албан тушаалтан байгаа ч ингээд цаашдаа энэ нь нэмэгдэх ийм бидний хараа хяналтаас сулраад үлдчих тийм их боломж төрийн өмчийн ийм компаниуд дээр байгаа гэж бид нар харж байгаа. Тэгээд энэ авлигын гэмт хэргийг үйлдэх, эсвэл аливаа гэмт хэрэгт орох ийм нөхцөл суурь болохыг бол үгүйсгэхгүй байна гэж.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбоо холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Нарантуяа-Нара гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн, Ганбат гишүүн орж ирж байна. Ганбат гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгэхээр авлигал гэдэг энэ зүйлтэй тэмцэхийн тулд зөвхөн энэ байгууллагын асуудал биш, тэгэхдээ Авлигатай тэмцэх газар бас

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тодорхой түвшинд координацыг хангаж, соён гэгээрүүлж, гарсан энэ гэмт хэргийг таслан зогсоож, илрүүлж зохих байгууллагад нь уламжилж бас хариуцлагыг нь тооцуулах ажил эдний нуруун дээр байгаа. Энэ төсөөллийн индексийг бууруулах энэ ажил дээр төрийн байгууллагын бүх шатны байгууллагын оролцоотой байдаг гэдэг зүйлийг бас олон нийтэд зөв ойлгуулах талаас Авлигатай тэмцэх газрын энэ авлигатай тэмцэх ажил эхлэх юм байна.

Энэ ажил дээр гол авлигын индекс урагшлахгүй байгаа шалтгааныг сая хэлж байна л даа. Улс төрийн намын санхүүжилт ил тод бус, ТӨК хэт олон, томилгоо, сонгон шалгаруулалт нь ил тод бус, тендер худалдан авалтын маргаан маш ихээр үргэлжилдэг. Тендер худалдан авалтын худалдан авах ажиллагааны төлөвлөлт буюу төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт ерөөсөө анхнаасаа буруу явдаг ийм зүйлүүдээс болж энэ авлигын индекс чинь урагшлахгүй гэдэг зүйлийг олон улсын байгууллага хэлээд байгаа.

Д.Цогтбаатар: Учрал сайд гарч явахгүй биз дээ?

П.Сайнзориг: Дарга би үг хэлж байсан та уг нь тэгээд.

Д.Цогтбаатар: Зөв зөв таныг би гүйцээгээд өгье.

П.Сайнзориг: Ийм зүйлээс болдог юм. Мэдээж энэ гарч байгаа хэрэг маргааныг илрүүлэх ажил байгаа. Дээрээс нь ерөөсөө энэ авлигыг бас өдөөж байгаа зүйл бол энэ хүртээмжгүй бус байдлууд байгаа. Дэд бүтцийн хүртээмжгүй байдал гэдэг бол цаана нь авлигал цэцэглэх суурь үндсэн хуулийн шалтгаан болж байгаа юм. Өнөөдөр 1 байшин сав барья, үйлдвэр завод барья гээд явахад дулаан, цахилгаанд холбогдохоос эхлээд энэ хүрэлцээгүй буюу хүртээмжгүй байдлыг ашиглаж хэн түрүүлж энд холбогдох вэ гэдэг зүйлийг бизнесийнхэн ч эрэлхийлдэг, нөгөө талдаа холбогдох албан тушаалтнууд ч энэ дээр бас гарын үсгээ үнэлдэг ийм зүйлүүд байна.

Тэгэхээр бид хэд авлигатай тэмцэнэ гэдэг энэ дээрх хууль тогтоомжуудаас гадна энэ нийгмийн суурь дэд бүтцүүд буюу хүний хэрэгцээтэй энэ бизнесийн орчныг явуулах энэ дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж байж энэ бас явна.

Өнөөдрийн бас парламент дээр батлагдсан энэ төмөр замын хэлэлцээр ч гэсэн өнөөдөр тээврийн дагасан авлигал ямар их байгаа билээ. Гэтэл ерөөсөө ганцхан Замын-Үүдээр бүгдээрээ ачаа бараагаа татаж байгаа хүртээмжгүй байгаа учраас л энийг дагаж байгаа байхгүй юу. Гэх зэргээрээ энэ авлигын энэ асуудлыг бид нар маш олон зүйлүүдээс бас суурь шалтгаан нөхцөлүүдийг үнэлж, энэ дээрээ шийдвэр гаргах түвшин буюу хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх, хөрөнгө оруулалтаа тавьж өгөх асуудлууд байгаа шүү гэдэг зүйлийг бас хэлмээр байна. Тэгээд сэтгэлгээний ч асуудал байж болно.

Тухайлбал, бид нар хүүхдүүдээ хүмүүжүүлэхдээ ийм юм хийчихвэл чамд чихэр өгнө биш, чи ийм зүйлийг сайн хийсэн байна гээд урамшуулдаг энэ сэтгэлгээг хүртэл гэр бүлийн хүмүүжил дээр авчирч байж өнөөдөр бид нарын сэтгэлгээ хандлага өөрчлөгдөнө. Бид хэд юм хийсэн бол заавал шан харамжтай байдаг юм байна гэдэг ойлголтыг гэр бүлийн хүмүүжил дотор ч гэсэн өгдөг. Харин бусад оронд буюу энэ зүйлийг хүнтэйгээ ажилладаг орнуудад чи ийм зүйлийг дүрэм, журмын дагуу найз нөхөдтэйгөө хамтарч сайн хийсэн байна гээд

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

урамшуулдаг байх жишээний. Тэгэхээр бид хэд ийм л зүйлээс энэ зүйлүүд бас эхлэх ёстой гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм.

Тэгээд би бас Дашдаваа даргыг ерөнхийдөө дэмжиж байна. Таны үед батлагдсан энэ Авлигыг тэмцэх үндэсний хөтөлбөр, энэ бичиг баримтад тусгагдсан энэ хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Засгийн газрын холбогдох сайдуудтайгаа бас нягт ажиллаач. Өнөөдөр бас, өнөөдрийн энэ танхимд Алтангэрэл сайд бас сууж байна. Шүгэл үлээгчийн хуулийн эрх зүйн байдал, шүгэл үлээгчийг хамгаалах, энэ шүгэл үлээх үйл ажиллагааг дэмжих энэ хуулиудыг яаралтай оруулж ирээч. Би бас яг Хууль зүй, дотоод хэргийн яаманд байж байхдаа энэ дээр ажиллаад бэлэн байгаа. Улсын Их Хуралд өргөн барьж байсан хэлэлцэх эсэх асуудлууд л шийдэгдэж байсан ийм хэмжээний хууль байгаа. Тэгэхээр энийг яаралтай оруулж ирмээр байна. Төрийн бус байгууллагын хуулийг яаралтай оруулж ирмээр байна. Өнөөдөр хүртэл гишүүд яг үнэндээ хэлэхэд энэ хууль тогтоом.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүнд 1 минут нэмж өгье.

П.Сайнзориг: Тэгээд энэ төрийн бус байгууллагын асуудлаар гэхэд гишүүдийн энэ хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил энэ тэр дээрээ хүртэл мөнгө төгрөгөө төрийн бус байгууллагаар л гаргаж байгаа байхгүй юу. Бид бас өөрсдөөсөө эхэлмээр байгаа шүү. Энэ гишүүдийн ард өнөөдөр хоёр хоёр төрийн бус байгууллага гэх юм бол бараг хоёр, гурван зуугаад төрийн бус байгууллага л энэ дээр ингээд байж байгаа шүү дээ. Энийгээ Төсвийн хууль энэ тэртэйгээ уялдуулаад шийдчихмээр байна. Тендерийн хуулиа яаралтай оруулж ирээд сайжруулчихмаар байна. Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хуваарилах хуулиа хийчихмээр байна. Тэрнээс биш ял хариуцлагыг чангатгаад бүх зүйл шийдэгдэхгүй байна гэдэг зүйлийг бид нар хаа хаанаа бас ойлгох ёстой. Энэ мэдээж бодлогын нэг хэсэг.

Тэгэхдээ бусад асуудлыг шийдэхгүйгээр авлигатай тэмцэхэд бас том алхаж чадахгүй. Тийм учраас энэ шат шатдаа энэ ойлголтоо нэгтгээд бас хаа хаанаа бас энэ зүйл дээр бас зохистой үйл ажиллагаануудыг хиймээр байна. Тэрнээс биш яриад байдаг, эс үйлдэхгүйгээрээ ерөөсөө юу ч хийдэггүй ийм зүйлүүд байна. Тийм учраас бас энэ хууль, эрх зүйн орчин, эргээд энэ.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ер нь өнгөрсөн таны 6 жил, энэ 6 жил ирээдүйд болох 6 жилийг ингээд харьцуулаад харахад энэ авлигатай тэмцэнэ гэхэд бол үнэхээр хүнд хэцүү нөхцөлтэй байгаа юм. Би цөөнхийн бүлгийн даргаар 3 жил ажилласан. Тэр үед манай цөөнх, сөрөг хүчин арваадхан гишүүнтэй байсан, хэт олонх байсан. Тэгээд улс төрийн нөхцөл байдал ийм үед бас авлигын суурь энэ бүх юм хүнд хэцүү байдаг. Одоо болохоор бид нар ингээд хамтарч байгаа. Яах вэ олон түмний хүлээлт бол юу гэж байна вэ гэхээр бүтээн байгуулалт хийнэ, хүмүүсийн амьдрал сайжирна гэсэн ийм хүлээлт байгаа юм л даа. Тэгээд энэ хүлээлт 1 жилийн дараа дуусна. Бид нар чинь хуулиас дээгүүр ийм хамтрал хийчхээд, засаг хийчхээд ингээд явж байгаа шүү дээ. Би таныг ажиллаж байх үеэ харьцангуй хараад байгаа. Ямар ч байсан эрх баригчидтай бас ажилласан. Нэлээн хэдэн хүн шүүхээр гэм буруутай нь тогтоогдчихсон. Би хэн нэгнийг гэм буруутай нь шүүхээр тогтоогдоогүй

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байхад хэнийг ч тийм ийм гэж хэлэх эрхгүй. Хэдийгээр би чуулган дээр, Байнгын хороон дээр үг хэлэхдээ хариуцлага хүлээдэггүй ч гэсэн.

Тухайлбал, миний мэдэхийн тэр хамаг авлига янз бүр болчихоод байна гээд л ингэж ярьдаг тэр Тавантолгойн захирал нь шүүхээр яваад л ял авчихлаа. Ямар зүйл ангиар авсныг нь мэдэхгүй. Бас энэ дээр Авлигатай тэмцэх газрын ажил байгаа байх. Бас Улсын Их Хурлын дарга хийж байсан хүн бас ял авчихлаа. Тэгэхээр эрх баригчдын өмнөөс бас ингээд асуудлыг гаргаад тавиад байгаа нь бас нэг талдаа бас авлигын чадан ядан тэмцээд байна. Хүсэл зориг байна гэж би ойлгоод байна.

Тэгээд нөгөө нөхцөл нь хууль өөрчлөгдөөгүй байхад Ерөнхийлөгчөөс санал болгож Авлигатай тэмцэх газрыг тавьдаг байсан бол одоо ингээд Засгийн газраас Ерөнхий сайд нь өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд ингээд санал болж байна. Засгийн газар энэ Авлигатай тэмцэх газрын авлигатай тэмцэх ажлыг манлайлж явах нь. Тэгэхээр бас байдал өөр байх нь уу, үгүй юу гээд харъя л гэсэн бодолтой байна. Яг эрх баригчидтай тэр авлигын асуудлыг яриад, тэмцээд ингэж байсан шигээ бас энэ юмыг гаргаарай.

Нөгөө талаар цөөнх байхад ямар нэгэн улс төрийн хүчний ганц нэг холбогдсон улсуудыг хэлмэгдүүлж болохгүй шүү. Энэ талаас нь анхаараарай. Гэхдээ хууль нь байна, байгууллага нь байна, хийх ажил нь байна. Олон нийт хүлээж л байна л даа. Авлигын асуудал, авлигатай тэмцэх энэ ард түмний амьдрал улных болчихоод байгаа ийм нөхцөл байдалд ингээд хараад яваад байж болохгүй байна. Одоо ингээд шийтгэл авч байгаа улсуудыг харахад дандаа л гавьяатууд, цолтой тийм хүмүүс л ял аваад байна шүү дээ. Тэрийг бас ингээд шийдэж барих юм байгаа байх. Маргааш мэдээж хэрэг би асуулт асууна чуулган дээр хэд хэдэн хуулийн төслийн талаар таны санал бодлыг сонсоно гэсэн ийм бодолтой байна. Ер нь тэгээд ирж байгаа хийх ажилд чинь амжилт хүсье гэж.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Ер нь бол түрүүнийхээ асуулттай бас уялдаад үг хэлмээр байгаа юм. Тэгэхээр ер нь аливаа томилгоо, аливаа албан тушаалтны хараат бус байдал гэдэг бол өөрөө субъектив нөлөөлөл буюу хүний нөлөөлөл байхгүй болох л асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ нөлөөлөл субъектив буюу хүний нөлөөлөл байхгүй болох гол нөхцөл өөрөө гэхээр үнэлгээний үзүүлэлтүүд, тоонууд өөрөө буцаад хувирах боломжгүй. Тэгэхээр энэ үнэлгээ болон жишээлбэл сая ярьж байна шүү дээ жишээлбэл олон улсын авлигын төсөөллийн индекс буурчихсан байна, эсвэл өсөхгүй байна, энэ нь өөрөө ажил хийгдээгүй гэдэг харагдаад байна ч гэдэг юм уу.

Гэтэл энэ чинь бол өөрөө үнэлгээний нэг л индекс байхгүй юу. Нэг л үзүүлэлт. Тэгэхээр энэ дээр үзүүлэлтүүдээ маш сайн тодорхойлоод гаргаад өгчих юм бол дараа нь жишээлбэл илүү субъектийн хувьд биш хийсэн ажиллагаа нь ажлын үнэлгээний хувьд тухайн албан тушаалтныг үнэлдэг болоод дараагийн томилгоо, эсвэл томилгоо болгон дээр шалгуур үзүүлэлтүүд нь тодорхой болоод эхлэх юм бол энэ нь өөрөө илүү субъектив биш объектив шийдвэр гаргалтад нөлөөлнө. Энэ талаасаа ч гэсэн би бас эрсдэлийн, нөлөөллийн эрсдэлүүдээ тодорхойлсон уу гэж асуугаад байгаа нь яг энэ дээр ингээд тодорхойлоод гаргах

юм бол ер нь улс төрийн нөлөөлөл, улс төрчийн нөлөөлөл бол өндөр гарах болов уу гэж харж байгаа юм.

Тэгэхээр яг энэ томилгоо дээр орж ирж байгаа улс төрчдийн зүгээс тийм угаасаа яг хэргийн эзэд чинь өөрөө энэ улс төрчид дунд л байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээрээ ямар нэгэн байдлаар субъектив нөлөө орохгүй байх тэр нөхцөл байдлыг хангах үүднээс энэ шалгуур үзүүлэлтүүдээ аягүй сайн тодорхойлж гаргаасай. Дараа дараагийн ажлуудаар одоо ингээд 6 жил дахиад томилогдоод ороод ирлээ гэхэд энэ хараат бус байдлаа бий болгохын тулд тоо худлаа хэлэхгүй гэдэг шиг яг энэ үзүүлэлтүүдээ аягүй сайн нарийн гаргаад өгчихвөл цаашдын ажилд нь бас нэлээн тус дэмтэй байх болов уу гэж харж байна.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Авлигатай тэмцэх ганцхан Авлигатай тэмцэх газрын ажил биш. Тэр дотроо 90 хувь нь ер нь улс төрөөс, Засгийн газраас улс төрчдийн өөрсдийнх нь манлайллаас хамаарна.

Тэгэхээр тэр хүрээнд би нэг зүйлийг хэлье. Сая Дашдаваа дарга ер нь энэ төрийн өмчийн компаниудад гол авлигын асуудал байгаа, энийг хянахад бэрх болж байгаа шүү гэдэг бас үг хэлж байна. Энэ бол үнэн. Одоо энэ бүтээмжийн менежер гээд Сайнзориг, Мэндсайхан гишүүн бид 3 Ерөнхий сайдад асуулт тавьчихсан байгаа. Төрийн өмчийн 123 компани 400 бүтээмжийн менежер гэсэн орлогч захирлын статустай, сардаа 5-6 сая төгрөгийн цалинтай, машин унадаг сар тутам нийт дүнгээрээ 30, 3 тэрбум, жилдээ 30 тэрбумын цалин, зөвхөн цалин шүү авдаг ийм албан тушаалтнууд томилж байгаа юм байна. Энэ улс төрийн авлига. Энэ намуудыг дуугүй болгох гэж байгаа юм. Найран дундаа идэж уух гэж байна гэсэн үг. Энийг энэ хүмүүс дээр тэгээд Авлигатай тэмцэх газар хуулийн хүрээндээ сайн хяналтаа тавиарай. Улс төрийн хүрээнд энэнтэй нь бид өөрсдөө тэмцэнэ. Гантөмөр Ардчилсан намын дарга ингэж хэлсэн байна. Бүтээмжийн менежер гээд дотор нь манайхан хүнээ оруулж байгаад хянах гэж байгаа юм гэж хэлсэн байна. Доржханд ХҮН намын дарга бол манай намынхан дандаа ухаантай хүмүүс томилж байгаа. Манай намынхан дандаа ухаантай хүмүүстэй учраас асуудал гаргахгүй гэсэн байна лээ.

Тэгсэн мөртөө бие биеэ зодоод нүдээд байгаа. Намын дарга нь хэлэхдээ манай намынхан хүн зодох нь байтугай дандаа эхнэрүүд нь л нөхрүүдээ зодож байдаг болохоос биш манай намынхан хүн зоддоггүй гэж яриад байгаа юм. Тэр айлын эхнэрүүдийг яаж байгаа юм ард түмний өмнө? Тэгсэн чинь Сангийн сайд гарч ирснээ энэ 400 бүтээмжийн менежерийг томилсон чинь төсөвт ямар ч зардал нэмж гарахгүй гэж яриад байгаа юм. Энэ цалингүй ажиллах гэж байгаа юм уу? Би бүүр гайхаад байх юм. Ингээд ерөөсөө худлаа яриад. Энэ дээр гол авлига яригдана. Миний санаж байгаагаар 3 жилийн өмнө Авлигатай тэмцэх газар төрийн өмчийн компаниуд дээр 10 их наядын авлигын асуудал байгааг олон түмэнд мэдээлсэн. Энэ бол 3 тэрбум долларын асуудал ярьж байгаа юм. Энэ нь ч үнэн, бодитой гэдэг нь өнгөрсөн хугацааны бүх үзүүлэлтүүдээр нотлогдсон. Төрийн өмчийн 1 компанийн захирлын сейфээс 7.5 тэрбум төгрөг бэлнээр хураагдаж байсан. Энэ дээр Засгийн газар өөрөө бас манлайлж ажиллах ёстой энэ Алтангэрэл сайд хаачихав? Авлигатай тэмцэх газар илрүүлээд шийтгээд байдаг. Тэгсэн чинь 7.5 тэрбум төгрөг сейфтээ хураалгаад баригдсан Батдөл гэж нөхөр өнөөдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Богд уулын амралтын

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

газар ял эдэлж байгаа юм байна лээ. Богд ууланд амралтын газар шүү дээ. Тэгээд энэ Засгийн газар яагаад байгаа юм энэ? Энийг тэр амралтын газар амрааж байгаа сайд байна гэсэн үг. Мөнгө мэддэг сайд байх гэж байгаа юм. Өөрийг нь илчлээгүйн төлөө Богд ууланд тэр хүнийг амрааж байна гэсэн үг. Тийм учраас эзнийг нь олж шийтгээрэй цаашдаа. Эзэн нь их тодорхой харагдаад явчихсан байна лээ шүү.

Д.Цогтбаатар: Нарантуяа гишүүн Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр авлигатай тэмцэх ажил, асуудал бол бүх нийтийн асуудал. Бүх нийтийн үйл хэрэг мөн. Авлигатай тэмцэх газрын хамрах хүрээний асуудал бол зөвхөн улс төрийн хүрээнийх ч юм уу, төрийн эрх мэдэлтнүүдийн авлигал, хээл хахуулийн асуудал бас биш байдаг. Авлигатай тэмцэх газрын асуудал хамрах хүрээнд бас иргэн болон иргэнээс дээгүүр эрх мэдэлтэй хэн ч байсан тэр хүмүүсийн хоорондын харилцааг бас шийддэг ийм ажил бас байдаг. Өнгөрсөн хугацаанд Авлигатай тэмцэх газарт жишээлбэл иргэн болон цагдаагийн албан хаагчийн эрүүдэн шүүсэн хэргийг цаг тухайн үед нь хариуцлагатай, хянамгай, хүний эрхийн мэдрэмжтэй, иргэний төлөө гэсэн сэтгэлээр ажиллаж чадаагүй ийм алдаа, дутагдлаас болж хэрэг, тэр эрүүдэн шүүсэн хүнийг таниулах ажиллагааг хийж чадаагүй, танин мэдүүлж чадаагүй байж байгаад тухайн иргэн цагдан хоригдож байх явцдаа амь нас нь, амь насаа алдсан ийм харамсалтай тохиолдол болсон байдаг.

Тэгэхээр энэ тухайд ялангуяа Дашдаваа дарга дараагийн 6 жилдээ ийм алдаа огт гарахгүй байхын төлөө, ялангуяа өөрийнхөө удирдлага зохион байгуулалт доор ажиллаж байгаа АТГ-ынхаа бүх албан хаагчид, мэргэжилтэн, байцаагч, хэн байдаг юм тэр бүхнийгээ энэ бүх зүйлд хүний төлөө яг өөрийнхөө хүүхдийн төлөө явж байгаа юм шиг иргэний төлөө, хүний эрхийн мэдрэмжтэй, хүнлэг сэтгэлээр маш хариуцлагатай хянамгай ийм цаг нартай ажилладаг ийм байдлыг маш сайн сахиулаасай гэж бодож байна. Тэгэхээр зэрэг ямар ч л байсан дараагийн 6 жилд ийм иргэн болон иргэнээс дээрх эрх мэдэлтэй хэн хоорондын ийм асуудалд ямар нэгэн байдлаар Авилгатай тэмцэх газар цаг алдсан, боломжийг алдсан, тэндээс болж таниулах ажиллагаа хийгдээгүй, зохих ажиллагаануудад явагдаж чадаагүйн улмаас ингээд иргэн хүн хохирсон гэдэг ийм юм байхгүй байх гэж итгэж байна.

Тэгэхээр та хэрвээ дараагийн энэ сонгогдоод ажиллах бол энэ тал дээрээ бүүр маш сайн дээд хяналтыг тавьж, тэгээд асуудлыг үүссэн хойно нь албан хаагчийг ажил, албан тушаалаас нь огцруулах, халах ийм байдлаар биш харин өөрийнхөө удирдлага доор ажиллаж байгаа энэ бүх хүмүүстээ хүний эрхийн мэдрэмжтэй, хүний төлөө гэсэн энэ ажиллах хурд хүч, хариуцлага, сахилга батыг урьдчилан маш сайн ойлголт өгч бэлтгэж ийм асуудал гаргахгүйгээр ажиллаасай гэж хүсэж байгаагаа илэрхийлэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ундрам гишүүний микрофоныг өгье.

Ч.Ундрам: Одоо бодвол таныг гайхамшигтай сайхан ажилласан гэж бодож байгаа гишүүд нь, дахиад үргэлжлүүлээд ажиллаасай гэж бодож байгаа хүмүүс нь саналаа өгөөд явах байх л даа. Тэгээд яах вэ энэ таны нэр дэвшүүлж байгаа танилцуулгатай танилцахаар яг ингээд нэлээн улс төр оролцчихсон, тэгээд нийгэмд нэлээн шуугиан тарьчихсан, сэтгүүлчид, олон нийтийн дэмжлэг орчихсон

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ийм хэргүүдийг л шийдвэрлэсэн, араас нь явж байна шүү дээ. Ингээд л нүүрсний хулгай гээд л гадаа жагсаал гарсан, улс төрчид байр сууриа илэрхийлсэн. Ингээд л араас нь араас нь дандаа ингэж явсан ийм хэдэн хэрэг л байгаа юм. Тэгээд Боловсролын зээлийн сан дээр гэхэд яг тухайн үед нийгмийн шуугиан дунд байсан учраас тэр үед нь хүмүүс эргэн төлөлтөө яарч сандраад олноороо хийсэн байхгүй юу. Тэгээд дараа жилээс нь эргэн төлөлт байхгүй болчихсон. Энэ жил байхгүй.

Тэгэхээр энэ чинь ингээд ийм улс төрийн нийгмийн анхаарал татсан хэдэн хэргийн асуудал яриад байгаа болохоос цаана нь өшөө зөндөө олон хэргүүд яаж шийдэгдэж байгааг би хэлж мэдэхгүй байна. Ер нь бол Авлигын төсөөллийн индекс бол ганцхан танай байгууллагын ажлын үр дүн биш. Нийт энэ улс төрчид төрийн байгууллага, ТӨК-уд гээд ингээд олон хүчин зүйл байгаа.

Гэхдээ танайх яг энэнтэй тэмцэх гол чиг үүргийн бүүр ингээд хуулиар дархлагдчихсан ийм байгууллага нь шүү дээ. Тэгэхээр энэ оноо дийлэнх нь танай хийж байгаа, хэрэгжүүлж байгаа ажилтай бас холбоотой. Тэгэхээр цаашид ядаж энэ индексийг бид нар өсгөмөөр байна шүү дээ. Арга хэмжээ авмаар байна. Санаачилгатай танай байгууллагын зүгээс ч гэсэн ажилламаар байна. Энэ Хууль зүйн байнгын хороотойгоо ч юм уу. Тэгээд энэ байгууллагыг удирдаж, манлайлж авч явж байгаа хүн өөрөө хамгийн гол нь ашиг сонирхлоос ангид, бүр тэрний үлгэр жишээ байх ёстой. Ямар нэгэн улс төрийн албан тушаалтан ч юм уу, өөрийн хамаатан ч юм уу, нэгдмэл ашиг сонирхолтой этгээдээс ангид ажлаа хийж байж энэ ажил чинь сайн явдаг гэж би боддог.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Би 2 үг хэлье гэж бодож байна. Энэ авлигатай тэмцэх энэ төсөөллийн индекс дээр яах хэрэгтэй, тал талаасаа ер нь анхаарч ажиллах хэрэгтэй. Манай Хууль зүйн байнгын хорооноос ч гэсэн, Хууль зүйн яам, Засгийн газар энэ дээр бүгдээрээ анхаарч ажиллах ёстой. Яагаад гэвэл бүгдэд нь тавьж байгаа дүн энэ. Тэр өнцгөөсөө би юуг хэлмээр байна гэхлээр ингэмээр байна ер нь танай байгууллагаас яг одоо энэ асуудал гараад тэртээ тэргүй хүмүүс яриад байна шүү дээ. Тэгэхээр ямар ажлууд хийхээр төлөвлөж байна? Бидний зүгээс, Хууль зүйн жишээлбэл, Байнгын хорооны зүгээс бид яаж тусалж болох вэ? Би жишээлбэл өөрийнхөө хувийн зүгээс энэ олон улсын туршлага юмнуудаас судлаад, олоод та бүгддээ энэ дээр дэмжлэг үзүүлээд ажиллахад бэлэн байна. Тэгэхээр тэн дээр та нар яг тодорхой энийг яг асуудал болгож тавьж байгаад, тэгээд тодорхой Засгийн газар ингэж ажилламаар байна, Хууль зүйн байнгын хороо ингэж ажилламаар байна, манайх ингэж ажилламаар байна гэсэн нэг тийм саналуудаа боловсруулаад ирэх юм бол би энэ дээр нь өөрийнхөө зүгээс чадахаараа туслаад дэмжиж ажиллахад бэлэн байгаа шүү. Нэг ийм юу. Тэгээд тэн дээр ялангуяа энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүд төсөв нэмэгдэж байгаатай холбогдуулан энэ эрсдэл өөрөө цаанаасаа нэмэгдээд байгаа. Одоо яг таны дэргэд сууж байгаа Учрал сайд бол би тэр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг нэгийг ч нэмэхгүй гэдэг тогтоолын төслийг санаачилцаад өөрөө гарын үсэг зурж байсан. Энийг хамгийн сайн ойлгодог хүн байж байгаа.

Тэгэхээр засгийн зүгээсээ энэ дээр бас шаардлагатай бол бид нар ч Хууль зүйн байнгын хорооноосоо хамтарч ажиллаад энийгээ хэрэгжүүлэх тал дээр ажилламаар байна. Тэгэхгүй нээрээ энэ төсөв ийм том болчихсон байгаа, би түрүүн хэлсэн шүү дээ 100 хэдэн мянган хүн ажиллаж байгаа энэ салбарт бүгдийг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нь харж хянана гэвэл маш хэцүү болно шүү дээ энэ. Тэгэхээр өөрийн эрхгүй энэ учир шалтгааныг нь өөрийн номд нь оруулж номхотгож өгөхгүй бол та нар яаж ч ажлаа дийлэхэд маш хэцүү. Энийг л бас тал талдаа ойлгомоор байгаа юм.

Өшөө хоёр дахь нэг санаа би хэлмээр байна. Юу гэвэл танайх харин дотоод хяналтаа ер нь бас яаж сайжруулах вэ? Яагаад гэвэл энэ дээр чинь танай дотор бас өөрсдөд чинь ийм эрсдэл гарах магадлал өндөр байгаа шүү дээ. Яагаад гэвэл та нар хэнтэй ажилладаг вэ гэхлээр мөнгө, эрх мэдэл хосолсон ийм тоглогчидтой, улс төрчидтэй, эрх мэдэлтнүүдтэй тулж байгаа. Тэд нарын чинь нөлөө гар, хөл маш урт байгаа. Тийм учраас танай дотоод байгууллага руу чинь ч нэвтрээд орчих эрсдэл байгаа учраас дотоод хяналтынхаа системийг яаж сайжруулах вэ гэдэг дээр анхаарч ажиллаарай гэж би бас хэлмээр байна. Энэ дээр Хууль зүйн байнгын хорооны зүгээс ямар дэмжлэг үзүүлж болох вэ? Энийг бас та нар хэрэв бидэнд саналаа тавих юм бол бид өөрийнхөө зүгээс чадахаараа ингээд дэмжиж ажиллах болно.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалтдаа орно.

Монгол Улсын Ерөнхий сайдаас Улсын Их Хуралд ирүүлсэн Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилуулах тухай саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

72.2 хувиар дэмжигдлээ.

Тэгээд энэ дээр нэмээд Заяабал гишүүн, Да.Цогтбаатар гишүүн, Пүрэвдорж гишүүн дэмжсэнээр саналаа өгсөн байна. Энийг нь манайхан бүртгээрэй Хууль зүйн байнгын хорооныхон.

Баярлалаа. Энэ асуудал ингээд санал хураалт явж дууслаа. Улсын Их Хуралд Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир уншиж танилцуулна. Ингээд асуудал шийдэгдлээ. Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

16.59 цаг

Гуравдугаар асуудал. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг, гишүүд маань байж байгаарай. Хөөе энэ чинь тийм санал, сая хойшлуулчихсан хурал шүү дээ. Тийм. За тэгье.

Ингээд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар хэлэлцүүлгийг явуулъя.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Хууль зүйн байнгын хороон дарга би өөрөө танилцуулах юм байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн хуулийн зарчим мөн.

Арванес дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуульд зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж. Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.5 дахь зорилтыг хэрэгжүүлэх үе шат нь, 1 дүгээр үе шатад хүний эрхийг хангасан бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж, үр нөлөө дээшилнэ гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын Хүний эрхийн олон улсын гэрээ болох иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээ аваагүй байгаа бол энэхүү фактад оролцогч улс бүр Үндсэн хуулийн хуулийнхаа журам болон энэ фактын заалтад нийцүүлэн түүнд хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээг авах үүрэгтэй гэсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуульд 2023 онд оруулсан өөрчлөлтийн дагуу 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан 126 гишүүнтэй парламент шинэ тутам бүрдэж улмаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэгт заасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлаад байна.

Тус стратеги төлөвлөгөөний 1 дэх зорилтод хүн төвт хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлэхээр заасан бөгөөд хууль тогтоомжийн болон хууль тогтоомжийн төслийг боловсруулах, төлөвлөх, өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, тайлагнах үе шатад хүн төвт үзэл санаанд суурилсан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалсан байх зарчим, шаардлагыг тэргүүн эрэмбэд тавих зорилтыг дэвшүүлсэн.

Тэгвэл энэхүү зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс суурь нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлан хэрэгжүүлэх үндэс суурь нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлан боловсруулах хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж буй

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хууль тогтоомжийн тухай хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах явдал болно.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан. Ингээд Хууль зүйн байнгын хорооныхондоо энэ хуулийн гол нэмэлт, өөрчлөлтийн гол үзэл санаа, зорилго, агуулгыг товчхондоо танилцуулахад ийм байна.

Энэ хуулийг хэлэлцэхтэй холбогдон Хууль зүйн байнгын хороонд ирсэн байгаа ажлын хэсгийнхнийг танилцуулъя.

Ажлын хэсгийн гишүүд Алтангэрэл Улсын Их Хурлын даргын зөвлөх, Отгончимэг Улсын Их Хурлын даргын зөвлөх, Дондогмаа Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга, Агар-Эрдэнэ Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх, Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг энэ хуралдаанд оролцож байна. Ингээд миний бас зөвлөх Болд хуульч энэ ажлын хэсэгт оролцож байгаа болно.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа тушаалтнуудыг танилцууллаа.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Сайнзоригоор тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би ерөнхийдөө их асуух гэхээсээ илүүтэй үг хэлчихнэ. Тэгээд энэ хуулийг бас Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн тохиолдолд бас ажлын хэсэг заавал гаргаж нэлээн сайн ярихгүй бол яг энэ нөхцөл байдлуудыг буруу мэдэрдэг хүмүүс энэ хуулийг бичсэн юм уу? Би Цогтбаатар даргад л их л сонин юм гарт нь бариулчихсан байгаа юм даа. Энэ Захиргааны ерөнхий хуулиар явдаг зүйлүүдийг Хууль тогтоомжийн хууль дээр оруулж ирээд хэм хэмжээний батлах актын эрх олгох зохицуулалт дараах асуудлыг тусахгүй гэж байгаа юм. Албан татвар төлбөр, хураамж тогтоосон харилцаа гэж байгаа юм. Орон нутгийн эрх мэдлийг ингэж авч болохгүй шүү дээ. Орон нутаг буюу ИТХ, шат шатандаа Засгийн газар, магадгүй зарим хураамжийн асуудал дээр асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ч гэсэн дээд, доод хэмжээнд тааруулаад Улсын Их Хурлаас олгосон тэр бүрэн эрхийн хүрээнд татварыг тогтоодог байхгүй юу. Малын хөлийн татварыг хэдүүлээ 330 сумаар энд ярьж болохгүй шүү дээ. Тэгэхээр ийм зүйлүүдийг ингэж оруулж ирээд сүүлдээ энэ хууль батлагддаггүй шатлал руу ороод, орон нутаг ч мэдэхээ болиод явах нь ээ.

Дээрээс нь энэ татварын харилцааг зөвхөн хуулиар гэдэг бол өмнө байгуулсан энэ хөрөнгө оруулалтын гэрээ болон бүтээгдэхүүн хуваахад шууд нөлөөлнө. Тэнд тогтворжчихсон зүйлүүд чинь өөр тийшээ явах гэж байна. Тэгэхээр манай энэ хуульчид, боловсруулж байгаа хүмүүс жоохон бодолтой байгаач. Юу хийж, юу сэдээд байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хоёрдугаарт ингэж байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулийн хуульд заасан хүний эрх чөлөөг хязгаарлах харилцааг тусгаж болохгүй гэж байгаа юм. Яах вэ хуулиар эрх олгосон хүрээний хэмжээнд бас зохицуулалтаа хийж уг нь энийгээ хянах ёстой юм. Магадгүй тэр захиргааны хэмжээний актын хяналт бүртгэлийг Засгийн газар тэр дундаа Хууль зүй, дотоод биш Улсын Их Хурлын Тамгын газар дэргэдээ авчрах ёстой байхгүй юу. Дэргэдээ авчрах ёстой. Түүнээс биш жишээ нь ийм зүйл байдаг улсын хилээр импортоор оруулж ирэх бараа, материалын тоо хэмжээ хязгаарлалтуудыг тавьдаг ийм ийм зүйлүүдийг жишээ нь оруулахгүй гэж тавьдаг. Энэ нь тэгэхээр Үндсэн хуулийн хуульд заасан аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэхийг хязгаарлаж байна гээд сүүлдээ эргээд Улсын Их Хурал ингээд бараа, материалын жагсаалт батлаад явж байдаг ийм юм руу орчих вий дээ.

Энэ дараагийн ноцтой заалт байгаа. Энэ хуулийн 12.2-т заасан буюу Төсвийн хуулийг ярьж байгаа юм. Тухайн жилийн Төсвийн хууль. Хуулийн төслийг дагалдуулан бусад хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлэх тохиолдолд тухайн төслөөр зөвхөн төсөв, санхүүгийн харилцааг зохицуулна. Энэ өөрөө эргээд Монгол Улсын Үндсэн хуулийн хуульд хууль батлах квотын асуудлыг тусгаж өгөх концепцыг л ярих ёстой болохоос биш үүгээр ядаад магадгүй ингээд барилгын норм, дүрэм, стандартыг өөрчилье. Шинэ төрлийн жишээ нь харилцаануудыг өөрчлөөд төсвийг нь тавилаа гэхэд холбогдох Барилгын хуульд нь өөрчлөлт оруулж болохоо байчихлаа шүү дээ. Боловсролын хуульд нь өөрчлөлт оруулж болохоо байчихлаа шүү дээ. Хүүхдүүдийн хоолны мөнгийг нэмчихье гээд тэгдэг ийм ийм шаардлагуудыг хангасан ийм сургуулиудыг нэмнэ гээд тэгчихдэг Боловсролын хуулийг хөндөж чадахаа больчихлоо шүү дээ. Энэ Монгол төрийн үйл ажиллагааг гацаачхаж байгаа байхгүй юу. Тэгээд ер нь.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Микрофон гүйцээгээд өгье.

П.Сайнзориг: Бүлгийн ярьсан байгаа. Тэгээд би чуулган дээр ингээд хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явъя. Эндээс бас авах санаанууд бий. Би үгүйсгээгүй шүү. Тэгэхдээ ийм зүйлүүдийг жишээ нь хууль санаачлагч хүн уншихгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр та хэд мэдээллийг ерөөсөө өгөхгүй байна гэсэн үг боловсруулсан хүмүүс.

Тийм учраас би энийг Улсын Их Хурал дээр хэлэлцэх эсэхийг нь шийдсэн тохиолдолд ажлын хэсэг гаргах ёстой. Ажлын хэсгийг ахалж ажиллах ийм саналыг би бас Байнгын хорооны дарга, бүлгийн даргад тавьж байна. Энд бас нэлээн туршлагатай гишүүд бас орж дуугарахгүй бол энэ чинь ингээд сонин юм руу явах гээд байна шүү. Би энийг л хэлж байгаа юм. Ингээд асуулт алга байна.

Д.Цогтбаатар: Энэ дээр би 1 л хүн асуулт асуугаад, үг хэлэх гишүүд байна уу?

Үг хэлэх гишүүд байхгүй байна.

Тэгвэл би энэ дээр товчхон үг хэлчихье. Сайнзориг гишүүнээ энэ дээр ийм юм ярьж байгаа шүү. Жишээлбэл, өөрөө тэр квот, худалдааны тухай ярих гэж байгаа бол ёстой ингэж сууж байгаад би ярина шүү харин. Худалдааг чинь би ёстой А-гаас Б хүртэл ярина. Квот эд нар чинь байна шүү дээ хил дээр тавих тарифын асуудал бол дэлхийн аль ч улсад парламентын бүрэн эрхийн асуудал

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байдаг юм. Сая Трамп эксэктив/executive/ шийдвэрүүд гаргаад байгаа энэ чинь эцсийн дүндээ Конгресс дээрээ очиж шийдэгдэнэ.

Тэгэхээр энэ саяын энэ, одоо жишээлбэл хэрэв бараа, бүтээгдэхүүнд ямар нэгэн өөрийн чинь төсөөлж байгаагаар ярьж байна шүү дээ энд тэгж заагаагүй байгаа. Гэхдээ иймэрхүү юмнууд орж ирж байгаа бол энэ чинь хуульдаа тодорхой зааж өгөөд журмууд ийм ийм чиглэлээр журам гаргана гээд тэр журмынхаа хүрээнд л гаргана. Журам заагаагүй юман дээр ямар нэгэн тийм хязгаарлалт хийхгүй. Өөрөөр хэлбэл, энэ хуулийн, тогтоолын төсөл дээр өөрөө ингэж хэлээд байх шиг байна л даа Цогтбаатар гишүүн уншаагүй оруулаад ирчихсэн. Би одоо зөнөчхөөгүй л байна л даа. Малан тэнэг бүүр ч болоогүй байгаа. Тэгэхээр энэ дээр хуулийнхаа үзэл баримтлал юмнуудыг бид нар харж байгаад хийж байгаа бөгөөд тэр зөвхөн журмаар хуульд заагаад өгчихсөн тэр журмынхаа хүрээнд тэр өөрийн чинь яриад байгаа эрх шилжүүлэх тэр эрх чинь үүгээрээ шилжээд тэр хүрээндээ энэ нь хийгдээд явна. Тийм, тэгэхээр тэрүүгээрээ энэ боломжууд чинь бүгд нээлттэй байгаа. Зөвхөн тэрийгээ тодорхой зааж өгье. Тэгэхгүй бол хуульд заагдаагүй журам өөрсдөө гаргаад, өөрсдөө хүмүүсээс хураамж хураагаад ингээд яваад байгаа юмнуудыг чинь л хааж өгье гэж байгаа юм.

Түүнээс тийм журамд заагаагүй юмнуудыг хуульдаа бид нар журамтай л болгоё, тэр журмынх нь үүд, хаалгыг нээж өгч байгаа. Манай ажлын хэсгийнхэн энэ дээр нь гүйцээгээд хариулна биз. Өөрөө хуульч байж жишээлбэл, зах зээл дээр би уншсан харин тийм. Надаа их заагаад байх хэрэг байхгүй. Тэгээд өөрөө ороод ажлын хэсэгт нь ороод яриад явахгүй юу. Би өөрт чинь хэлсэн шүү би өөрөөр чинь хууль заалгахгүй. Тийм. Үгүй тэгээд бариад яриах дээ. Наадах чинь хууль боловсруулагдаад явж байна. Энийг чинь л хэлэлцэнэ гэдэг юм. Тэгэхгүй ер нь энд орж ирээд их омогшоод хүн загнаад байдаг чамд ерөөсөө загнуулахгүй хөөе. Чи юм болгон дээр орж ирж хүн загнадаг болчихсон. Чамд ерөөсөө загнуулахгүй. Түрүүн, энэ би микрофонд ярих эрхээ эдэлж байна. Би чамайг ярихад юу ч яриагүй. Би чамайг ярихад юу ч яриагүй. Би харин тэрэнд чинь тэгээд хариултыг нь л өгч байна. Энэ хөрөнгө оруулалтын гэрээний тухай түрүүн ярьж байна. Энэ ноцтой юм ярьж байна. Ийм юм байхгүй. Буцаж энэ хууль чинь үйлчлэхгүй юм байгаа биз дээ? Эс үгүй бол үйлчилнэ гэдэг тийм текст хийсэн юм уу? Тийм юм байхгүй шүү дээ. Тэгэхээр чинь олон улсын тэр гэрээ чинь өөрөө давамгайл үйлчлээд явна. Тэгэхдээ тийм зорилго ч энэ гэрээний юунд байхгүй, энэ хуулийн заалтад байхгүй.

Энэ хуулийг тайлбарлахдаа үзэл баримтлал, санааных нь хүрээнд тексттэй нь тайлбарладаг юм. Энийг тайлбарлах дүрэм гэдэг юм. Үзэл баримтлалаас нь зөрүүлж тайлбарлана гэж бас байхгүй. Ийм байна. Тэгэхээр зүгээр саналаа яриад, ажлын хэсэгт ороод энийгээ сайжруулаад явах эрх хэнд ч байж байгаа.

Гэхдээ би энд сууна уу, тэнд сууна уу хэнд ч загнуулахгүй. Зүгээр ажил төрлөө яривал яриад явах ёстой тийм.

Отгончимэг гишүүнд микрофон өгье. 6 дугаар микрофон.

Н.Отгончимэг: Нэмж тодруулга өгье. Хуулийн төсөл санаачлагч маань тодруулж өгөөрэй гэсэн учир Татварын ерөнхий хуулийн 8.1-д ямар заалт байдаг вэ гэхлээр татварын хувь, хэмжээг гэж байгаа юм. Улсын Их Хурал түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, хотын зөвлөл

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно гэж байдаг. Тэгэхээр энэ хуулийн төсөл дээр орж ирсэн албан татвар, төлбөр, хураамж тогтоосон харилцааг журмаар зохицуулахгүй гэдэг нь хувь хэмжээнд огт хамааралгүй.

Өөрөөр хэлбэл, тодорхой шинэ төрлийн татвар хураамж бий болгох гэж байгаа бол үүнийг журмаар зохицуулахгүй гэдэг ийм шаардлагыг тавьж байгаа юм. Гагцхүү тухайн тогтоосон татвар, хураамжийнхаа хувь хэмжээг Улсын Их Хурал, иргэдийн хурал, эсвэл Засгийн газарт эрх олгоод хувь хэмжээг нь тогтоох бүрэн эрх Татварын ерөнхий хуулиараа нээлттэй байгаа. Энэ харилцаа бол цаашид үргэлжилнэ.

Д.Цогтбаатар: Асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлж дууслаа. Энийг ингээд томьёолол хаана байна? Ингээд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д Байнгын хороо хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасны дагуу санал хураалт явуулъя.

Санал хураалтыг цуцалъя.

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Номинчимэг гишүүн горимын санал гаргая.

О.Номинчимэг: Сая төхөөрөмж дээр бас энэ хурууны хээ уншигдсангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтыг түр цуцалъя.

Отгонбаяр гишүүн горимын санал гаргая.

У.Отгонбаяр: Уучлаарай сая дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажиллаагүй учраас саяынхыг цуцлаад дахиж санал хурааж өгөхийг хүсэж байна.

Д.Цогтбаатар: Түрүүн Отгонбаяр гишүүний горимын саналыг хүлээж авъя гэхэд өнгөрчихсөн учраас бид нар хүлээж авах боломжгүй байна.

Тэгэхлээр одоо санал хураалтаа цаашаа үргэлжлүүлээд явъя.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Манайхан идэвхтэй оролцоорой.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Номинчимэг гишүүн дэмжсэн байна. Дэмжсэнээр аваарай

3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

61.1 хувиар санал дэмжигдлээ.

4.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулан өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Манайхан идэвхтэй.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Цогтбаатар би өөрөө санал өгсөн боловч энд сая улаан гарчихлаа. Тийм учраас намайг дэмжсэнд бүртгээрэй.

Ингээд санал хураалтын, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг? Тэгвэл хэн байх вэ? Соронзонболд гишүүн танилцуулчих уу? Соронзонболд гишүүн танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

17.31 цаг

Дөрөвдүгээр асуудал, Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэл танилцуулна.

Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын хүн төвтэй үйл ажиллагааны үзэл баримтлал, Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Хүний эрхийн олон улсын гэрээ конвенц, хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлүүд, түүнчлэн Хүний эрх дэвшилт бодлогын хүрээлэн ТББ-аас хийсэн Монгол Улсад хүний эрхийн төлөв байдал, тулгамдсан асуудал, шийдэл сэдэвт тойм судалгааны зөвлөмжүүдийг үндэслэн дараах хуулийн төслийг боловсруулаад байна.

Нэгдүгээрт, нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааны төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг энэ чиглэлд уялдуулан зохицуулах замаар Монгол Улсын иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах зохицуулалт бүхий Хууль зүйн туслалцааны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

2.Хуульчийн хувьд бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ, эрх зүйн иргэний боловсролыг дэмжих зорилготой үйл ажиллагааг буюу үйл ажиллагааг буюу нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг Хууль зүйн туслалцааны тухай хуультай уялдуулах зохицуулалт бүхий Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

3.Эрүү шүүлт тулгах, хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн шинжийг олон улсын гэрээ, конвенц, зөвлөмжид нийцүүлэн тодорхой болгох зорилгоор боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

4.Баривчлах шийтгэлийг оногдуулахгүй байх этгээдийн хүрээ хязгаарыг иргэдийн зүй ёсны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх. Хуулийн тусгай ангид заасан зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах баривчлах шийтгэлийг цөөрүүлэх, Улсын Их Хурлаас баталсан зарим хуультай холбогдуулан зөрчилд тооцох үйлдлүүдийг шинээр тусгах зэрэг зохицуулалт бүхий Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

5.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон шүүх прокурор эрх бүхий албан тушаалтнууд бий болдог хүндрэл чирэгдлийг багасгах, цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх зарим төрлийн хэргийн харьяаллын алдааг засах зохицуулалт бүхий Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

6.Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдөр буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл хэвээр үйлчлэхээр заасан зохицуулалтыг өөрчилж, биелэгдээгүй байгаа зөрчлийг хүчингүйд тооцох зохицуулалт бүхий Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

7.Монгол Улсын иргэнийг Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх журмыг боловсронгуй болгох, хилийн хориг тавих эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоог хангах сайдын тушаалаар зохицуулж байсан хүүхдийг хилээр нэвтрүүлэх журмыг хуулиар зохицуулах зорилгоор боловсруулсан Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

8.Албаны нууцын тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох, албаны нууцын хүрээ хязгаарыг багасгах, байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамааруулж байгаа зохицуулалтыг эргэн харах, иргэдийн мэдээлэл авах эрхийг хязгаарлаж байгааг арилгах зорилгоор боловсруулсан Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

9.Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хараат бус байдлыг хангах, иргэний нийгмийн болон мэргэжлийн байгууллагын бодит оролцоог хангах, тэдгээрийг нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох зохицуулалтыг бий болгох зорилгоор боловсруулсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

10.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх бүхий хуульчдад олон улсын гэрээ, конвенцын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ. Уг асуудлыг хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт тусах хөшүүрэг бий болгох зохицуулалт бүхий Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

11.Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулах шаардлагад хүний эрхийг хангах шалгуур бий болгох зохицуулалт бүхий Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хуулийн төслүүд батлагдсанаар олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг, тэдгээр байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, хүний эрхийн үндэсний байгууллага, төрийн бус байгууллагуудын санал, эрх бүхий байгууллагаас Засгийн газарт даалгасан арга хэмжээ, хууль тогтоомжид хүний эрхтэй холбоотой зөрчил, дутагдлыг засахад тодорхой ахиц дэвшил гарна гэж үзэж байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Алтангэрэл сайд өөрөө Хууль зүй, дотоод хэргийн сайд, Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Батболд Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч бөгөөд хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Батзориг, Сандаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Батдэлгэр Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга, Эрдэнэлхагва Цагдаагийн ерөнхий газрын Хэрэг бүртгэх албаны Зөрчлийн хэрэг бүртгэлт мэргэжлийн арга зүйн хэлтсийн дарга, Сувд-Эрдэнэ Хил хамгаалах ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга, хурандаа, Лхагвацэнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Амарсайхан Хууль зүйн туслалцааны төвийн Мэргэжил арга зүйн хэлтсийн дарга, Мандах Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн шинжээч, Ганзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Маяа Гэр бүл, хөдөлмөрийн нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн ахлах шинжээч гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна. Ажлын хэсгийг танилцууллаа.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Номинчимэг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Энд уг нь өргөн барьсан бүх асуудлыг хэлэлцээд уг нь сайжруулах ёстой гэдэг дээр санал нэг байгаа юм. Эхний ээлжид хууль зүйн техникийн юм асууя. Энэ хүний эрхийг, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэдэг нэртэй хууль Монгол Улсад байхгүй. Аль хуулийн хувийн хэрэгт энэ мэдээллүүд чинь орох юм бэ? Уг нь энэ багц хууль чинь Боловсролын багц хууль гэж яриад Боловсролын ерөнхий хуулиа дагаад сургуулийн өмнөх ч юм уу, эсвэл Дээд боловсролын хууль хамтдаа орж ирэх асуудлыг болохоос биш хүний эрх гэдэг ийм алаан дотор хийчихээр яг аль хуульд бид нар нэмэлт, өөрчлөлт оруулаад, үүнтэй холбоотой ямар ямар хуулиудыг дагалдаж байгаа юм бэ гэдэг зүйлүүд чинь ингээд тодорхойгүй болчихлоо. Энэ дээр Улсын Их Хурлын Тамгын газар хариулж өгөх юм уу? Ийм зүйлүүд ингээд орж ирээд байхаар энэ Хууль тогтоомжийн хуулийн чинь 14.4-тэй зөрчилдөөд байна. Энэ дээр нь ямар байр суурь байгаа вэ? Нэгдүгээрт.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хоёрдугаарт яах вэ энэ Өмгөөллийн хууль дээр ингээд энэ асуудлыг уг нь ярьдаг юм. Тэгээд тодорхой эсвэл хураамж авдаг байдлыг Алтангэрэл сайд дэмжих үү? Хүн болгон бас яг эрүүгийн эрх зүйгээр бас мэргэшсэн биш. Тэгээд яг томилолтын өмгөөлөгч хийе гэхээр яг иргэний юм уу, захиргааны чиглэлээр явдаг хүмүүс чинь бас их хүнд туслах гэхээсээ илүүтэй сүүлдээ нийтэд тустай үүргийг заавал хийх ёстой гээд, нөгөө талдаа бас чанартай үйлчилгээг үзүүлж чадах уу гэдэг бас л үүд байгаа. Тэгэхээр энэ чиглэлийн гэдэг юм уу хүмүүс нь хураамж төлөөд, орж ирсэн хураамжаар нь яг эрүүгийн чиглэлийн хүмүүсийг нь авч ажиллуулдаг ийм тогтолцоо байж болох уу? Энэ дээр бас ямар байр суурьтай байна вэ гэдэг зүйл нэгдүгээрт байна.

Хоёрдугаарт, Эрүүгийн хууль дээр хүнтэй доромжлон харьцах асуудлыг гэмт хэрэг болгож байгаа юм байна. Энэ хэрэгцээ шаардлага ямар байгаа учраас бас энийг оруулж ирж байгаа вэ? Та бас хэлж өгөөч.

Хоёрдугаарт, энэ Зөрчлийн хууль батлагдахаас өмнө Захиргааны хариуцлагын хууль байдаг юм уу, бусад хуулиар оногдуулсан зөрчлийг үндсэндээ торгууль, шийтгэлийг өршөөх гэж байна л даа. Энэ хэчнээн хүний асуудал, хэчнээн зөрчлийн асуудал байгаа вэ? Хэдэн төгрөгийн торгууль шийтгэлийг ингээд чөлөөлөх асуудал ороод ирэв ээ? Энийг бас та бас хэлж өгөөч.

Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль дээр бас Монгол Улсынхаа нэрийг бас заримдаа халууцуулдаг үйлдлүүдээр нь бас хүмүүс гаргаж байгаа. Зарим оронд ч гэсэн дипломат шугамаар нот бичиг илгээдэг юм байна лээ Монгол Улсад. Ер нь эргээд бас визтэй болох уу? Танайхан ирээд хулгай зэлгий бөөндөө хийгээд байна гээд. Тэгэхээр ер нь гадаадад хулгай хийж байгаа асуудал нь бид энэ Монгол Улсын хуулиар зохицуулж болохгүй л дээ. Тэгэхээр дипломат шугамаар ийм төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүмүүс дээр энэ тавих хязгаарлалт дээр нэмж өгч болох уу? Иргэний гадаад паспорт авах эрхийг нь тодорхой хугацаагаар хязгаарладаг ч юм уу. Энэ чинь бүлэглээд баахан хулгай хийчхээд ирж байгаа хүмүүс байгаад байгаа юм биш шүү дээ. Тэгэхээр энэ дээр орж байгаа өөрчлөлтөөр бас уялдаж бас хийх харилцаа байна уу, үгүй юу? Та бас байр сууриа хэлээч гэж байгаа юм.

Тэгээд нэг харамсалтай юм байна Алтангэрэл сайд. Энэ яах вэ Харилцаа холбооны хууль байна. Та хэд маань бас юмыг жоохон анзаарч орж ирэхгүй бол энэ хуулийн танилцуулга дээр миний зүгээр сэтгэлийг эмзэглүүлж байгаа нэг л зүйл байна. Энэ томилгооны асуудлыг хөндөж орж ирэхдээ юу гэж хэлсэн бэ гэхээр танилцуулга дээр .../минут дуусав.

Д.Цогтбаатар: Хэддүгээр микрофон, Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Сайд хариулах уу? Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Сайнзориг гишүүний ярьж байгаа энэ Өмгөөллийн тухай хуультай холбоотой нэн ялангуяа пробоны үйл ажиллагаатай холбоотой асуудлууд байгаа юм. Бид бол энэ статистик энэ төлбөрийн чадвар гэдэг үнэ төлбөргүй үзүүлсэн өмгөөллийн үйлчилгээний тоон мэдээлэл гээд авсан юм. Тэгээд энэ авангуут 2023, 2024 онд яг 1 л хувийн өмгөөлөгчтэй гэрээ байгуулаад 7 сар ажиллуулсан байгаа. Тэгээд ер нь тийм асуудлууд байгаа. Иргэн, захиргааны чиглэлийн өмгөөлөгч нар байгаа. Одоо яг яаж зохицуулж байна вэ гэхлээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал гараад ноднингийн 7 сарын 1-нээс хэрэгжиж

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

эхлэх ёстой байсан зүйлээр ингээд журам гаргаад Өмгөөлөгчдийн холбоонд даатгаад ингээд яваад байгаа юм.

Ер нь Өмгөөлөгчдийн холбоонд урьд өмнө нь явж ирж байсан жишиг тэр жилдээ 2 удаа хууль зүйн туслалцаа үнэгүй үзүүлнэ гэж байх үед ч тэр, гаргасан журмын дагуу эрүүгийн хэргээр дагнан ажиллах сонирхолтой, эрүүгийн хэрэг дээр бас ажиллаад үзье гэсэн хүсэлтэй энэ хүмүүс ажилладаг байсан. Тэгээд бид нарын зохицуулж байгаа хүрээ хязгаар ерөөсөө төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээг яваад, эндээс үнэхээр тухайн орон нутаг болоод нөхцөл байдал, төрийн үйлчилгээ хүрэлцэхгүй болсон тохиолдол гарч байгаа учраас бид нар ачааллыг хэт өндөр гэж үзэхгүй байгаа. Өмгөөлөгчдийн өнөөдрийн байгаа тоо, тэгээд Өмгөөлөгчдийн холбооноос авсан санал. Энэ зүйлээс бид нар өмгөөллийн үйл ажиллагаа доголдоно гэж үзэхгүй байна.

Тэр Эрүүгийн хууль дээр бид нар энэ хүнийг хүчээр алга болох гэмт хэргийн шинжийг олон улсын гэрээ, конвенцод нийлүүлж байгаа юм. Тэгээд энэ эрүү шүүлт тулгахтай холбоотой зүйл дээр нь вэ гэхээс энэ доромжлохыг бас яг ингээд хуульчлаад тусад нь гэмт хэрэг болгоод явсан зүйл байхгүй гэдгийг хэлье.

Энэ гадаадад зорчихтой холбоотой асуудал дээр түрүүнд хүүхдийг хилээр гаргахад Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан журмаар явдаг. Тэгээд энийг хуульд нь оруулж байгаа юм. Нөгөө талаар бас 2 удаа өөрөөсөө ч шалтгаалах үндэслэлээ 2 удаа гадаад паспортоо үрэгдүүлсэн бол хилээр гарах эрхийг нь хязгаарлана гэдэг ч юм уу энэ хүний эрхийг хязгаарласан зүйлүүд байсан. Энэ зүг, энэ тэгээд энэ чиглэлийн зүйлүүдийг л алга болгож байгаа юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооны хувьд бид нар олон улсын зөвлөмжөөс энэ Харилцаа холбооны зохицуулах хороо чинь хэвлэл, мэдээллийн хэрэгслийг хязгаарлах энэ үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой тодорхой шийдвэрүүд гаргаад байна. Тэгсэн мөртөө энэ тодорхой шийдвэр гаргаж байгаа хүмүүс чинь ийм томилгоотой байдлаар төрөөс өөртэй нь хамааралтай байж болохгүй байна л гэсэн ийм зөвлөмжүүд өгөөд байдаг юм байна лээ. Тэгэхээр энийг сонгон шалгаруулалтын Үндсэн хуулийн дээр хараат бусаар томилох юм энэ үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд чинь нөлөөлж болзошгүй байна гэсэн энэ зөрчлөөсөө ер нь гарах юм байна гэдэг үндэслэлээр л яг энэ хуулийг боловсруулсан юм.

Харин тэр процесстой холбоотой зүйлүүд дээр нь харин манай ажлын хэсгээс тайлбар өгөх үү?

Д.Цогтбаатар: Хэддүгээр микрофон? 6 дугаар микрофон.

Н.Мягмар: Асуултад тодруулж хариулъя. Энэ багц хуулийн асуудалтай холбогдуулаад асуусан асуултад хариулъя.

Хууль тогтоомжийн хуульд хуучин 22.1-д багц хуулийн төсөл гэсэн зүйл байсан бол хүчингүй болоод багц хуулийн төсөл гэдэг боловсруулалт байхгүй болсон. Гэхдээ 24.2-т зааснаар бол хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хууль нэгэн зэрэг өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд бол тус тусад нь үзэл баримтлал тодорхойлох шаардлагагүй гэдэг энэ агуулгын

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хүрээнд Улсын Их Хурлаас өгсөн үүрэг болон тогтоолоор өгсөн үүрэг хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлийг хэлэлцүүлээд гаргасан тогтоолууд болон хүний эрхийн, НҮБ-ын Хүний эрхийн байгууллагуудаас өгсөн зөвлөмжөөр өгсөн зүйлд энэ хүний эрхийг хангах чиглэлд бол хувь.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулах боломж олгоё. 6 дугаар микрофон.

Н.Мягмар: Хүний эрхийг хангах чиглэлд хууль тогтоомжийн зохицуулалтуудаа сайжруул, хүний эрхийг хангах чиглэлд тодорхой хуулиудыг тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зэрэг хүний эрхийг хамгаалах чиглэлд байгаа хуулиудаа сайжруул гэдэг хүрээндээ хүний эрхийг хангах чиглэлд буюу энэ тодорхой асуудлаар хуулийн төслийг багцлан боловсруулж ингэж оруулж ирж байгаа. Тийм учраас Хууль тогтоомжийн хуульд заасан энэ агуулгын хүрээнд энэ хуулийн төслийг боловсруулж оруулж ирж байна.

Нөгөө талаасаа бас Улсын Их Хурлаар энэ өргөсөн үүргийн хүрээнд бол эргээд биелэлт тайлагнадаг. Тийм учраас энэ хүний эрхийг хангахтай холбоотой хууль тогтоомжийг ингэж ингэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж боловсруулсан гэдэг тайлагналын хувьдаа ч гэсэн эргээд бас энэ Хууль тогтоомжийн хуульд нийцсэн энэ боловсруулалт бол нийцэхээр байгаа юм.

Доромжлон харьцах холбоотой үйлдлийг гэмт хэрэгт яагаад оруулж ирэв гэдэг энэ асуудал бас хөндөж асуулаа. Энэ.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон гүйцээгээд хариулъя.

Н.Мягмар: НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос мөн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий доромжлон харьцаж шийтгэх эсрэг конвенцын дагуу бол энэ конвенцын хуульд нийцэж эрүү шүүлт тулах гэмт хэргээ та бүхэн нийцүүл гэдэг энэ зөвлөмжийг бол 2017 оны зөвлөмж энэ тэрд орсон байдаг. Үүний дагуу эрүүдэн, эрүү шүүлт тулах гэмт хэргийг бол өмнөх парламентын үед тодорхойлж оруулж ирсэн энэ төслийг бол бас хангалтгүй байна. Конвенцод нийцүүл гэдэг энэ агуулга бол бас эрүү шүүлт тулах хүний эрхийн тайланг, Засгийн газрын тайланг хэлэлцүүлэх үед бас яригдсан.

Тийм учраас энэ өөрөө гарч явах боломжгүй, эмнэлэг, цэргийн анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ч гэдэг юм уу, сэтгэцийн эрүүл мэндийн төв ч гэдэг юм уу энэ байгууллагад хүнтэй зүй бус доромжлон харьцах ийм асуудлууд байна. Энэ нь эрүү шүүлт тулгахын нэг тал хэлбэр биш боловчиг энэ конвенцын агуулгад нийцүү.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Яах юм, гүйцээж хариулах юм уу? Яагаад гэвэл нэгэнт ярьж байгаа юм чинь энэ хүний эрхийн асуудал дээр гүйцэд тайлбаруудаа өгөх нь зөв. 6 дугаар микрофон өгье.

Н.Мягмар: Энэ агуулгаар конвенцын агуулгад бүрэн нийцүүлэх гэдэг энэ зөвлөмж яригдсан учраас бид бүхэн эрүү шүүлт тулгах гэмт хэргээ тусгай субъект буюу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах чиг үүрэгтэй байгууллагуудын этгээдүүдэд хамаатуулж томъёолоод, тэрнээс бусад энэ хүн өөрөө гарч явах бололцоогүй гэж байгаа түрүүний дурдсан байгууллагууд дээр энэ хүнлэг бус, хэрцгий доромжлон харьцах гэдэг энэ зүйлийг ялгаж оруулж ирж бүхэлдээ энэ конвенцын агуулга бол

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

манай Эрүүгийн хуулиар хамгаалагдсан гэдэг энэ зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнах зорилгоор бол энэ конвенцын агуулгад нийцүүлж энэ гэмт хэргийн зүйл бол орж ирж байгаа.

Зөрчил шалган шийдвэрлэх хуулиар зөрчлийн тодорхой чөлөөлөгдөж байгаа ийм асуудлууд ярьж байгаа. Ер нь бол зөрчилд тооцохгүй болсон 30.5 сая буюу 1200 зөрчил асуудал байна. Шийд.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Болох уу? Номинчимэг гишүүний микрофоныг өгье. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Энэ ийм байна энэ агуулгыг бүгдийг нь би батлагдаасай, өөрчлөлтүүд яваасай гэж бодож байгаа юм. Тэгэхдээ Хууль тогтоомжийн хууль дээр 14.5 дээр ерөнхийлж байгаа хууль нь аль юм бэ гээд. Тэгэхээр энийг ерөөсөө энэ баталж болохгүй байгаа байхгүй юу. Бид хэд ийм хууль зөрчсөн хуулийг өргөн бариад хэлэлцээд батлах юм бол энэ харин Хууль тогтоомжийн хуулиар зөрчил болоод аль хуулийн хувийн хэрэгтэй энэ асуудлууд орох юм бэ гэдэг асуудал чинь гацах гэж байна.

Тэгэхээр энийгээ Алтангэрэл сайд аа уг нь энэ яамны хүмүүс чинь ингээд худлаа хариулаад байх юм. Зөв болгож орж ирэх ёстой байхгүй юу. Боловсролын ерөнхий хууль яаж байгаа бол тэрийг дагаад бусад хуулиудыг яаж байгаа болохоос биш энэ чинь аль ч хуулиар хүний эрх гээд ерөнхий юм ярьчихаад бид хууль зүйн туслалцааны хуульд өөрчлөлт оруулаад байгаа юм уу, Эрүүгийн процессын хуульд өөрчлөлт ороод мэдэхээ байчихаад байна шүү дээ. Үүнтэй уялдаа холбоотой юмыг л өөрчлөлт оруулах юм.

Тэгээд энэ харилцаа холбооны улс дээр АНУ-ын төрийн департментын Монгол Улсын 19 оны хүний эрхийн тайланд туссаны дагуу Харилцаа холбооны хуулийн өөрчлөлтийг өөрчлөлтийг хийчих юм уу? Бид арай ч нэг улсын тайлангаар хууль тогтоомжийн өөрчлөлтүүдээ шийдүүлэхээр болоогүй болоогүй байгаа шүү. Ийм зүйлүүд ингээд тусгаж орж ирчихээд ийм хариуц.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Хэн хариулах юм? Хариуцлагагүй хүмүүс нэг хариулаадхаач. 6 дугаар микрофон.

Н.Мягмар: Хууль тогтоомжийн хууль дээр бол хууль хоорондын зөрчил, давхардал, хийдлийг арилгах зорилгоор бол хуулийн төслүүдийг багцлан боловсруулж болно. Энэ тохиолдолд үзэл баримтлалыг нь тус бүрд нь тодорхойлох шаардлагагүй гэдэг энэ хүрээндээ хүний эрхийг хангах чиглэлдээ л хууль хоорондуудын зөрчлийг арилгаж, уялдаатай болгож мөн журамд тусгаж байсан зохицуулалтуудыг энэ хуулийн төсөл боловсруулж ингэж л оруулж ирж байгаа.

Тийм учраас Хууль тогтоомжийн хуулиас заасан өөр зөрчсөн ийм хуулийн төсөл боловсруулж оруулж ирсэн гэж ингэж үзэхгүй байна.

Харилцаа холбооны хуулийн хувьд бол хүний эрхтэйгээ яагаад холбож орж ирэв гэхлээр энэ мэдээлэл авах эрх чөлөөтэй холбоотойгоор ялангуяа иргэд бол мэдээлэл авах эрхтэй холбоотой энэ зүйл бол чухал байдаг. Тэгэхээр энэ мэдээллийг хүргэдэг харилцаа холбооны байгууллагуудад тусгай зөвшөөрөл

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

олгодог энэ байгууллага дээр энийг шийдвэрийг гаргадаг, хамтарсан шийдвэр гаргадаг энэ байгууллага бол улс төрөөс хараат байна. Нэг этгээдээс.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Яах юм гүйцээж хариулах юм уу? 6 дугаар микрофон.

Н.Мягмар: Нэг этгээдээс хамааралтайгаар хүмүүсийг томилж, чөлөөлж байна. Мөн 2, 4, 6 гэсэн энэ энэ янз бүрийн ойлгомжгүй ийм зохицуулалтууд энэ тэр байгаа учраас энэ хууль дээр бол энийг нээлттэй сонгон шалгаруулалтаар тодорхой бүлгийн мэргэжилд заасан бүлгүүдийнхээ хүрээнээс нь нэр дэвшүүлж энийг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгон шалгаруулж томилъё. Эргээд энэ маань бол мэдээлэл авах эрхийг хангах хэвлэл, мэдээллийн байгууллагууд, харилцаа холбооны салбарт ажиллаж байгаа тусгай зөвшөөрлүүдэд олгодог энэ шийдвэртээ олон нийтийн энэ оролцоог хангасан ийм төлөөлөл бүхий субъектүүд бол шийдвэрээ гаргадаг байя гэдэг энэ агуулгаараа бол хүний эрхийн чиглэлийг хангах чиглэлд энэ хуульд өөрчлөлт оруулах ийм хуулийн төсөл орж ирж байгаа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Бүгдэд нь өнөөдрийн энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхийдөө үзэл баримтлалын хувьд бас ингээд хүний эрх чөлөөг хангахтай багц хуулийг олон хууль бас байна дэмжиж байна. Гэхдээ бас нарийвчилж мэдээж Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарахаараа нэлээн нарийвчилж харах ёстой юмнууд их байна гэж харж байгаа.

Би зүгээр өнөөдөр нэг л юм илүү тодруулж асуумаар байна. Энэ Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулахаар орж ирж байгаа. Яах вэ мэдээж одоо байгаа хуулийн түвшнээсээ ахиулаад бас шаардлагууд тавьжээ. Тэгээд ямар шаардлагад нийцсэн байх юм гээд. Тэгэхдээ ер нь бид нар тэр эрүүдэн шүүх асуудал байна уу, хүний эрхийг зөрчсөн асуудал байна уу, нийгэмд гарч байгаа энэ асуудал, сэтгүүлчдийн эрхийг хамгаалахтай холбоотой асуудал гээд. Энийг харахаар энэ төрийн болон албаны нууц гэдэг нэрийн доор нэлээн олон асуудал өрнөдөг өө. Бид нар энийг системээрээ энэ хуулиа бас харахгүй бол төрийн нууц гэж яг хэлэх юм, албаны нууц гэж яг хэлэх юм гэдгээ ялгаа заагтай хармаар байгаа юм.

Тэгээд одоогийн хуулиа харахаар төрийн нууцад нэлээн олон өндөр түвшний олон нууц мэдээллүүд ийм юмыг заана гээд оруулчихсан. Албаны хуульд бол ердөө тийм юм байхгүй шүү дээ. Өөрсдөө тодорхойлно гээд орчихсон байгаа тийм үү? Албаны хууль гэдэг чинь төрийн байгууллагын өөрийнх нь үйл ажиллагаатай холбоотой, задрах юм бол ийм ийм ийм уршигтай ийм мэдээллийг хамруулж болно гэдэг нэгдүгээрт энэ тодорхойлолт буюу тодорхойлолтоо илүү оруулж өгөхгүй бол тэгээд ямар түвшнийх байх юм гэдэг юмаа оруулж өгөхгүй бол энэ дээр хууль дээрээ зөвхөн албаны нууцад хамаарах мэдээллийн шаардлагыг л ингээд оруулаад ирчхэж байгаа. Тэгээд ингээд харах юм энэ чинь ямар ямар чиглэлийн албан байгууллагын хувьд албаны нууцыг ямар зорилгоор нууцад авах юм гэдэг зорилгуудыг нь бас илүү тодорхой бичих шаардлагатай юм болов уу гэж харж байгаа.

Тэгээд хоёрдугаарт ер нь улс орнуудын энэ жишээг төрийн болон албаны нууцын, төрийн байгууллагын нууцын зааг ялгааг хараад түүнд оногдуулж байгаа

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

санкцуудыг нь, бас ялгааг нь бас сайн харах хэрэгтэй. Одоо энэ орж ирж байгаа хууль дээр тухайн байгууллага бол албаны нууцад хамаарах мэдээллийг энэ хуульд заасан шаардлагад, санкц дээр нь ерөөсөө төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хуулийн этгээдийн хууль бус үйлдлийг нуух зорилгоор мэдээллийн албаны нууцад хамааруулахыг хориглоно гээд хориглох заалт орж ирж байгаа. Үүний санкц нь юу байна гээд та бүхэн бас харах юм бол төрийн нууц задруулсан дээр эрүүгийн хариуцлага, Зөрчлийн хуулиар бол байгууллагын, төрийн байгууллага албаны нууцыг задруулах юм бол Зөрчлийн хуулиар л хариуцлага байгаа гэж ойлгож байгаа зөв үү?

Тэгэхээр хариуцлага дээр нь та бүхэн энэ дээр нэмэлтээр харах юм байсан уу? Энэ алийг нь төрийн нууцад хамруулах юм, алийг нь албаны нууц гэж ангилах юм гэдэг юман дээр зарим асуудал дээр төрийн нууцад хамруулсан тэр нэлээн том бүлгээс албаны нууц руу орохоор ч юмнууд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нууц байгаа байхгүй юу. Энэ дээрээ дахиж ангилан ялгалт хийх боломж байсангүй юу? Жоохон бүх бүхлээр нь харвал энэ хууль өөрөө маш том бас үр дагавар дагуулдаг хууль болохоор гэж харж байна. Тэгээд энэ дээр ямар төрлийн, энэ нууцлалын ангилал дээр та бүхний судалгаа хийсэн юмнууд байна уу? Ер нь.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Би ерөнхийд нь хариулъя. Тэгээд манайхан тэр тоо баримттай холбоотой зүйлээ нэмээд хариулна биз дээ.

Тэгээд Номинчимэг гишүүний яг харж байгаа зөв л дөө. Бид нар энэ төрийн нууцтай холбоотой асуудал албаны нууц гэдэг зүйлийнхээ ялгаа заагийг нэгдүгээрт гаргадаггүй.

Хоёрдугаарт, албаны нууцад хамруулах нь илүү хялбар байдаг учраас ер нь иргэдийн энэ мэдэх эрхтэй холбоотой мэдээлэл хүлээж авахтай холбоотой зүйлүүд дээр албаны нууц гэсэн ийм зүйлийн доор асар их оруулдаг юм байна. Төрийн нууц бол төрийн нууцын жагсаалт гэж байгаа. Тэгээд төрийн нууцад хяналт тавих эрх бүхий субъект, байгууллага холбогдох журам нь байдаг учраас ингээд яваад байдаг юм байна. Албаны нууц гэдэг нэрийн доор иргэдийн мэдэх эрхтэй холбоотой, тэгээд энэ хууль ёсны ашиг сонирхолд энэ хохирол учруулахуйц мэдээллүүдийг оруулаад байдаг юм байна гэдэг үүднээс бид яг энэ албаны нууцад нэлээн ач холбогдол өгсөн юм.

Ер нь энэ албаны нууцад байгаа зүйлүүдийг юу гэдэг юм төрийн нууцтай холбоотой зүйлүүд дээр Тагнуулын ерөнхий газар хяналт тавиад нууцын ажилтан гээд ингээд холбогдох журам үйлчилдэг шиг бид нар энэ албаны нууцад хамаарах мэдээлэл нь энэ дотор нь ил тод болгох мэдээлэл байна уу, үгүй юү гэдгийг бас хянадаг байя.

Хэрвээ энэ дотроо зүгээр нийтэд ил тод байх ёстой мэдээллийг албаны нууцад хамааруулаад байгаа бол хариуцлага тооцдог байя гэсэн ерөнхий л ийм асуудал оруулж байгаа. Тэгээд таны хэлж байгаа үнэн. Энэ төрийн нууц, албаны нууцын ялгагдаж байгаа тэр зааг, тэгээд төрийн нууцад яг хамаарах шаардлагатай мэдээллүүд бүрэн гүйцэт байгаа юу? Нөгөө талаараа хамгаалах ёсгүй зүйлүүдийг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

төрийн нууц гэдэг нэрийн доор бас бид нар байлгах шаардлагатай юу, үгүй юу гэдгийг бид нар эргэж харах шаардлага байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Тэгээд хэлэлцүүлгийн явцад тодруулаад явах байх гэж бодож байна. Манайхан тоо баримттай холбоотой зүйл дээр нь гишүүнд 7 номерын микрофон.

Д.Цогтбаатар: 7 номерын микрофон өгье.

Н.Жамъянхүү: Хууль зүйн дотоод хэргийн сайд Алтангэрэл сайдын тайлбар дээр нэмээд бид нар бас тодорхой албаны нууц дээр Тагнуулын ерөнхий газраас тодорхой мэдээлэл энэ тэр авсан юм.

Тухайлбал, энэ тоо баримтаар нийтдээ 39 төрийн байгууллагын, нийт төрийн нууцад 572, албаны нууцад бол 1043 ийм мэдээлэл, жагсаалт байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ дээр хамгийн гол асуудал нь өнөөдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй байх ёстой мэдээллийг иргэд, хуулийн этгээдэд хаалттай байдлаар, эсвэл хязгаарлалттай байдлаар ингэж мэдээлэл авах эрхийг зөрчиж байгаатай холбогдуулаад энэ төрийн байгууллагуудаас ялангуяа энэ албаны нууц нэрийн доор энэ мэдээллийг гаргаж өгөх иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад гаргаж өгөх энэ асуудал бас хойрго хязгаартай.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээх үү 7 дугаар микрофон?

Н.Жамъянхүү: Тэгэхээр энэ дээр ялангуяа энэ албаны нууц гэдэгт ямар төрлийн мэдээлэл байх ёстой юм бэ гэдэг гол үндэс, шаардлагыг нь бид нар энэ дээр, хуулийн төсөл дээр оруулж өгч байгаа.

Дээрээс нь бол энэ хязгаартай мэдээлэл дотор бол Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.2-т заасан хязгаартай мэдээллийг ямар үндэслэлээр бас иргэн, аж ахуйн нэгжид олгоогүй юм бэ гэдэг бас мэдээллийг эргүүлээд хариуг нь тайлбарлаж байх ийм бас хэд хэдэн зохицуулалт оруулж ингэснээрээ бол тодорхой хаалттайгаар мэдээллийг иргэдэд олгохгүй байх энэ нөхцөлийг бол бас тодорхой шалгууртай болгох, зарим тохиолдолд олгож байх ийм зохицуулалт энэ дээр орж ирж байгаа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүн тодруулах уу, үгүй юү? Тэгвэл ингээд хариулт тэгвэл хангалттай болсон байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Миний хувьд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой нийтдээ 11 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар оруулж ирсэн энэ төслийн хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Улсын Их Хурал хэлэлцээд, ажлын хэсэг гаргаад бас шуурхай хэлэлцээд баталбал, аль болох л хурдан л баталбал иргэдэд би сайн болов уу гэж ингэж бодож байна. Олон ч

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хуулийн үр өгөөжтэй байгаа талаар сая сайд танилцууллаа. Тэр дотроо жишээлбэл энэ иргэдийн мэдэх эрхэд хамгийн их хаалт болгоод байгаа асуудал бол энэ төрийн байгууллагын дарга, удирдлагууд, төрийн өмчийн компанийн захирлууд албаны нууц гэдгээр өөрсдөө янз бүрийн ийм хулгай, луйвраа нууцын дардас дарж тэр цаагуураа хулгай хийдэг энэ юмыг бас цэгцэлье гэж Алтангэрэл сайд оруулж ирж байгааг ер нь бараг түрүүлээд маргааш болов ч гэсэн баталчихмаар байна.

Энэний цаана өөрөө бас олон хулгай, луйвраа хаах энэ боломжийг бид дандаа таслан зогсоож байх ёстой. Тэгээд би энэ өөрт тохиолдсон явдлыг ярихад энэ жишээ нь өнгөрсөн үед би Нүүрсний сонсголыг бас удирдаж хийж байсан л даа. Тэгээд тэрний өмнө би энэ “Эрдэнэс Тавантолгой” компанийн бүтэц, орон тоо, тэгээд цалин, тэгээд жилийн дүнгээрээ энэ удирдлагууд нь ямар хэмжээний урамшуулал авдаг юм гээд асуулт тавьсан чинь надад албаны нууц гэдэг тамгатай хариулт өгч байгаа байхгүй юу. Албаны нууц. Тэгээд албаны нууц гэхээр би сонсгол парламентын ард түмний төлөөлөгч байх хяналт тавих тэр эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болчихсон. Ярих гэхээр би өөрөө Зөрчлийн хуулиар би шийтгүүлэх гээд байгаа байхгүй юу. Хууль зөрчсөн гээд. Тэгээд нөгөөдхийг нь харахаар энэ ямар ч энэ чинь нууц биш юм байгаад байгаа байхгүй юу. Зүгээр манай төрийн өмчийн компанийн бүтэц, орон тоо, цалинг нь асуухад нууц гээд дараад хариулчхаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ ер нь энийг нууцалж байгаа юм чинь энэ байтугай угаасаа цаагуураа сүйд болж байгаа юм байна гэж анх энэ сэдэл авсан юм.

Тийм учраас энэ албаны нууц гээд энэ байгууллагын дарга нар дураараа янз бүрийн хулгай, луйвраа хаацайлж энэ ард түмний мэдэх эрх, тэр дотроо ард түмний төлөөллийн байгууллага энэ Улсын Их Хурал хүртэл хяналт тавих энэ боломжийг хааж байгаа энэ юмыг өөрчлөх гээд оруулж ирж байгаа энэ санаачилгыг дэмжиж байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би энэ хуулийн хүний эрх чөлөөг хангахтай холбоотой гээд энэ хуулиудын агуулгыг бүгдийг нь дэмжээд байгаа юм. Тэгээд Улсын Их Хурлаас өгсөн үүрэг, бусад энэ хууль тогтоомжийн уялдааг хангах гээд ингээд явахаар уг нь 4 тусдаа үзэл баримтлалтай л хууль орж ирэх байж. Төрийн болон албаны нууцын хуулиар нэг, Өмгөөлөл, хууль зүйн туслалцаагаар нэг, Харилцаа холбоогоор нэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх буюу Зөрчил шалган шийдвэрлэх хуулиар нэг. Би энийг Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтэд оруулж өгөөч гэж байгаа юм.

Хууль тогтоомжийн хуулийн 14.4 дээр ийм үг байдаг л даа. Хууль санаачлагч нь тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэгт хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж өргөн мэдүүлж болно.

14.5.Энэ хуулийн 14.4-д заасан буюу дээр дурдсан заалтыг хэлж байгаа. Заасны дагуу хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг буюу аль нэг хуулийг үзэл баримтлал дээр тодорхойлох ёстой. Ерөнхий хуулийг дагаж анхдагч хуулийн төсөл

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл бүрээр илтгэн нэг үзэл баримтлалаа тодорхойлж болно гээд заалт.

Тэгэхээр энэ дээр аль ч хуулийн үзэл баримтлал байхгүй. Хүний эрх чөлөөг хангах гэдэг хууль байхгүй байхгүй юу. Тэгэхээр Хууль зүйн туслалцааны хуулиа уг нь малгайлаад ч юм уу, Эрүүгийн хуулиа малгайлаад тэгээд үүнтэй ингээд явах байтал ийм сонин ингээд процедураар ороод ирэхээр энэ цаашдаа буруу жишиг болчих вий л гэдэг зүгээр надад болгоомжлол байна. Тэгээд энийг Улсын Их Хурлын Тамгын газар бас маргааш чуулганаас орохоос өмнө энийг бас нягталж болохгүй юу? Би уг нь агуулгын хувьд ерөөсөө эсэргүүцээгүй. Тэгэхдээ анхнаасаа ингээд зөв явахгүй бол энэ олон зүйлүүдийг залхуурч нэг ийм малгай доор оруулаад Энхбаяр гишүүний хэлдэг шиг хуулийн хулгай янз янзын юм чинь л энэ жишгээр тогтоно. Тэгээд энийг уг нь ингээд өмнөх тэр дур дураараа явж байсан хуулийг багцалдаг байдлыг ингээд өнгөрсөн парламент буюу 23 оны 5 дугаар сарын 6-ны, 4-ний өдөр баталсан хуулиар уг нь цэгцэлчихсэн байхгүй юу.

Гэтэл энийг зөрчөөд ингээд тайлбар нь ч гэсэн худлаа ингээд гүжирдээд байна л даа. Тэгэхээр энийг яах вэ агуулгын хувьд дэмжээд байдаг. Хэлбэр, процессын хувьд ерөөсөө Хууль тогтоомжийн хуулийг асар зөрчөөд аль хуулийн хувийн хэрэгт энэ асуудлууд маань цаашдаа тусгагдаж орох нь мэдэгдэхээ байчих гээд ийм л жишиг болчихоод байна. Дээрээс нь яах вэ дэмжиж байна. Агуулгын хувьд дэмжиж байгаа.

Хоёрдугаарт, тэр нэг улсын ийм төрийн байгууллагын гаргасан мэдээлэл энэ тэрийг хуулийн танилцуулга энэ тэр хийдэг болоод л бид хэд өөр өөрсдийгөө л доромжилж байгаа хэрэг шүү. Тэр улсын төрийн байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслээд Харилцаа холбооны хуулийг өөрчлөхөөр орж ирлээ гэдэг чинь бас л арай ч дээ л гэж хэлмээр байна. Би энийг л тэгж хэлж байгаа юм. Энэ чинь бүхэл бүтэн тусгаар улс шүү дээ бид хэд. Энийг зүгээр ядаж нээлттэй ил тод болгох гэж байгаа юм гээд үндэслээд биччихгүй яав даа. Тэнд нэг байгууллагын улсын төрийн департментын тайлан дээр тэгээд биччихээр нь бид энийг ингэж ингэж байна гэдэг чинь бас л арай өөрөө өөрсдийгөө л жоохон доошоо хийгээд л байна. Тэгээд энийгээ бас ингээд хууль боловсруулах тэр баг нь бас жоохон анхаараасай л гэж бодоод байгаа юм. Бас сайдыг ийм юм арай ч биччих гэж хэлээгүй л байх. Ийм л зүйл байна. Тэгээд энийг би бас хэлмээр байна.

Агуулгын хувьд дэмжээд байгаа боловч хэлбэр, процессын хувьд жоохон асуудал байна шүү л гэдгийг би тодотгож хэлж байгаа юм. Хууль тогтоомжийн хуулийн 14.4, 14.5-ыг зөрчиж байна.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Энэ жоохон давхар яриад байхаар. Даргаа минутаа эхнээс нь авчихъя тэгэх үү?

Д.Цогтбаатар: Минутыг нь эхнээс нь өгье Уянгахишиг гишүүний.

Г.Уянгахишиг: Эдгээр хуулиудын төсөл дээр бол агуулгын хувьд санал нэг байгаа. Саяын бас Сайнзориг хуульчийн хэлснийг бас бодолцож үзэх ёстой л гэж харж байгаа юм.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Яагаад гэхээр хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой гээд хуулийн төслүүд тус тусдаа ч гэсэн зөндөө явж байгаа шүү дээ тийм ээ? Хэвлэлийн эрх чөлөөг хангах тухай, Жагсаал цуглааны эрх чөлөөг хангах тухай гээд. Яг энэ дээр ингээд багцлагдаад ороод ирсэн юм чинь өөрөө процессынх байна. Яг тэд нарыгаа тухай тухайн холбоотойгоор нэгтгээд ингээд оруулж ирсэн бол бас зүгээр байх байсан болов уу. Тэгэхгүй бол яг зүгээр хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой гээд ингээд багцалбал бүх хууль орж ирж болно шүү дээ. Тэгэхээр энийгээ бас тэр талаас нь бас хараасай гэдэг байна, хэлмээр байна.

Мөн түүнчлэн одоо хуульд хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой заалтууд, зохицуулалтууд нэмж оруулж ирж байгаа, засаж байгааг бол сайшаалтайгаар хүлээж авч байна. Гэхдээ өнөөдөр байгаа хууль тогтоомжоо бид нар бас сайн дагаж мөрдмөөр байна. Хэрэгжүүлэх дээрээ анхаармаар байна. Хүний эрх, эрх чөлөөг хангах тал дээрээ бас анхааралтай ажилламаар байна гэдгийг бас хэлмээр байна.

Жишээлэх юм бол шүүхээр гэм буруутайд тооцоогүй байхад хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй гэдэг гол Үндсэн хуулийн зарчим байдаг. Гэтэл сүүлийн үед хийгдэж байгаа мэдэгдлүүд дээр хууль зөрчсөн байх магадлалтай байна, эсвэл хууль зөрчсөн байна, эсвэл юу гэдэг юм бизнесүүд, хувийн хэвшилд ажиллаж байгаа компаниудыг хууль зөрчсөн, хэлцэл байгуулахдаа хууль зөрчсөн байна гэх мэтээр шүүхээр шийдвэрлэгдээгүй байхад нь буруутгадаг дайрсан ийм мэдээлэл өөрөө төрийн байгууллагын зүгээс гараад явахаар энэ чинь өөрөө буцаагаад яг хэн нэгэн гэдэгтээ гол нь биш, субъект нь чухал биш яг үнэндээ тухайн хувь хүний эрх чөлөөнд чинь бас халдаад байна. Нөгөө аж ахуй эрхлэх, бизнес эрхлэх, эрх чөлөөтэй байх, халдашгүй байх гэдэг энэ бүх эрхүүд чинь бас нөлөөлөөд байгаа учраас энэ тал дээрээ бас хэрэгжилт тал дээрээ бас цаашдаа бас анхаараасай гэж хэлмээр байгаа юм.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасны дагуу санал хураалт явуулъя.

Ингээд 1 дүгээр зүйл. Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Манайхан анхааралтай саналаа өгөөрэй.

61.1 хувиар Номинчимэг гишүүн бас дэмжсэн байна. Дэмжсэн гэж бүртгэж аваарай. Сайнзориг гишүүн дэмжсэн байна. Дэмжсэн гэж бүртгэж аваарай.

61.1 хувь, Тэгээд 2 гишүүнийг нэмээрэй.

2.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

61.1 хувиар санал дэмжигдлээ.

Нэмээд Бат-Амгалан гишүүн, Номинчимэг гишүүнийг санал дэмжиж өгсөн гэдгээр бүртгээрэй.

3.Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

72.2 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

72.2 хувиар санал дэмжигдлээ.

Одоо энэ 6 дугаар санал хураалт дээр надад нэг санал байгаа. Энэ томьёолол нь, хураалгах саналын томьёолол ийм байгаа.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хурал хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя гэсэн ийм томьёололтой санал байгаа юм.

Гэхдээ энэ дээр ийм зүйлийг хэлмээр байна. Энэ хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үндэслэл болох Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгэсэн бол хуулийг буцаан хэрэглэхгүй ба шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа тохиолдолд буцаан хэрэглэнэ гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэц дээр маргаан үүсээд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал томилогдсон байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг Үндсэн хуулийн цэцээс шийдвэр гарсны дараа хэлэлцэх нь зүйтэй гэсэн ийм саналтай байгаа юм. Тэгэхээр энийг дэмжихгүй байх тийм санал байгаа юм. Тэгээд санал хураалт явуулъя. Санал хураалт.

Үгүй энийг. Тийм бас нэг асуудал байгаа.

16 хувиар санал дэмжигдсэнгүй. Хууль санаачлагчид буцааж байна. Хууль санаачлагчид буцаая.

7.Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Тэгээд Сайнзориг гишүүн, Нара гишүүн дэмжсэн байна. Дэмжсэн гэж бүртгээрэй.

8 дугаар. Энэ чинь сая 7 байсан тээ?

8 дугаар асуудал. Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

72.2 хувиар санал дэмжигдлээ.

Энэ 9 дүгээр юун дээр бас надаа нэг санал байгаа. Энэ 9 дүгээр санал дээр.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулах ийм санал байгаа юм.

Гэхдээ энэ дээр яа яах аргагүй сая энэ гишүүдийн хэлээд байгаа асуудал яг энд гарч ирж байгаа. Хүний эрхийн асуудал гэдэг энэ том хүрээний дотор жишээлбэл, энэ албан тушаалын шинж чанартай ийм асуудал ороод ирж байгаа юм. Би энийг эсэргүүцээгүй, энэ хэрэгтэй, зөв байж болно. Тэгэхдээ хүний эрхийн асуудалтай энэ яг энэ багц хуульдаа хамаарахгүй байгаа учраас тусад нь та нар хууль бариад орж ирээрэй гэж хэлмээр байгаа юм. Тэгэхээр энийг дэмжихгүй, хэлэлцэхийг дэмжихгүй байхыг би бас гишүүддээ хүсэж байна. Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй. 0 хувь.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

72.2 хувиар санал.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

72.2 хувиар санал дэмжигдлээ.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ганбат гишүүн танилцуулах уу? Пүрэвдорж гишүүн? Тийм тийм үү? Сайнзориг гишүүн танилцуулах уу?

Сайнзориг гишүүн.

Үгүй үгүй энэ дэмжиж байгаа тийм. Ингээд Сайнзориг гишүүн танилцуулахаар боллоо. Өшөө байж байгаа шүү манайхан түр хүлээж байгаарай. Тавдугаар асуудал. Ер нь л дууслаа шүү. Манайхан түр жоохон тэвчээдэх. Жоохон тэвчээрэй манайхан. Тавдугаар, гишүүд ээ түр байж байгаарай. Бат-Амгалан гишүүнээ буцаад орж ирнэ биз дээ? Номинчимэг гишүүн ээ? Ганбат гишүүн байж байна шүү.

Мөнхбаатар гишүүн яаралтай ажил гарсан тул надаас чөлөө аваад явсан. Тийм учраас Мөнхбаатар гишүүнийг ирцээс хасахыг хүсэж байна. Тавдугаар асуудалдаа орёе.

18.00 цаг

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэлд танилцуулна.

Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 18 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зохицуулах зорилгоор Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт болон Монгол Улс дахь болон хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлд тусгасан дүгнэлт, зөвлөмжид нийцүүлж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төсөл боловсруулсан.

Хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа.

Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх. Гэрчийн мэдүүлэг авах үед түүний гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсох, хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах хэргийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх. Хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг нотлох баримтыг үнэлэхгүй байх.

Шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулдаггүй байх эрх зүйн орчныг тодорхой болгох. Олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтоох. Хавтаст хэргийг цахимжуулах журмыг боловсронгуй болгох. Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмыг нарийвчлан зохицуулах.

Шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох. Хорих ял эдэлж байгаа ялтанг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авсан үеэс хорих ялын хугацаа дуусахаар бол хуульд заасны дагуу цаашид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шүүх шийдвэрлэх.

Хуульд заасны дагуу бэхжүүлсэн дуу, дүрсний бичлэгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хадгалах хугацааг нарийвчлан тодорхойлох.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг уялдуулах.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцах, таслан сэргийлэх арга хэмжээ авах, шүүхийн хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн хуулийн дээр явуулах, яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, хэргийн оролцогчийн эрхийг хангаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараагийн шатанд хэргийг шилжүүлдэг байх.

Мөрдөгч прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах, хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй бол яллагдагч, шүүгдэгч энэ талаар нотлох баримтыг шүүхэд гаргах.

Хүн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолыг гардуулан өгөх.

Шүүх, прокурор, мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах зэрэг болно.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хуулийн төсөлтэй холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээл арилж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан халдашгүй чөлөөтэй байх болон өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах Үндсэн хуулийн эрх улам бүр баталгаажиж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцнэ.

Хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Хосбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Батцэрэн. Би уншаад явчихлаа. Ирэх байх. Улсын Ерөнхий прокурорын орлогч Төрийн хууль цаазын шадар зөвлөх Чинбат, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Жамъянхүү, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Батзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Намсаманд, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга Батдэлгэр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Лхагвацэнд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Эрдэм-Ундрах, Монголын криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Батзориг гэсэн, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Данзанноров ирчихсэн байна. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өнөөдөр Байнгын хороонд оролцож байна. Хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцууллаа.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү.

Байхгүй байна.

Тэгж болохгүй л дээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт байхгүй байлаа.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Хуулийн төсөл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байхгүй байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д заасны дагуу санал хураалт явуулъя.

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Тэгэхдээ түр хүлээж байгаарай. Ганбат гишүүн сая бас яаралтай ажил гараад чөлөө аваад явсан тул ирцээс хасахыг хүсч байна.

Ингээд Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д заасны дагуу санал хураалт явуулъя.

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

64.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

64.7 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд гишүүн Заяабал гишүүн танилцуулчих уу?

Заяабал гишүүн танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё. Одоо сүүлийн асуудал байгаа шүү гишүүд ээ түр байж байгаарай

18.32 цаг

6.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг гишүүн танилцуулна. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Г.Уянгахишиг: Өнөөдрийн өргөн барьсан хууль бол Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл байгаа.

Танилцуулгын хувьд бол Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзах тохиолдлыг тусгасан. Үүний 8.6.3-д энэ хуулийн 15.1.12, 15.1.13-д заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа гэж заасан нь шалгалтад орох хуульчийн эрхийг дордуулж байна гэдэг үндэслэлээр энэхүү хуулийг өргөн бариад байна.

Өмгөөллийн тухай хуулийн 15.1.12, 15.1.13-д өмгөөллийн үйл ажиллагаанд хавсран эрхэлж болохгүй албан тушаалыг тусгайлан заасан нь өмгөөллийн үйл ажиллагааг хараат бусаар эрхлэх боломжийг бий болгох зорилготой. Тухайлбал, өмгөөлөгч нь төрийн албан тушаалыг хавсран эрхэлсэн тохиолдолд шүүн таслах үйл ажиллагаанд нийгмийн бүхий л салбарт ажиллаж, амьдарч байгаа этгээдүүдийн хууль ёсны төлөөлөгч болохын хувьд албан тушаалтны нөлөөнд автах, эсхүл ажил, албан тушаалаар дамжуулан нөлөөлөх, давуу байдал үүсэх зэрэг эрсдэлийг үүсгэнэ гэж үздэг.

Гэтэл хуульчийг өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрх авах эсэх нь тодорхойгүй үе шат буюу өмгөөллийн шалгалтад бүртгүүлэхэд тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, 15.1.13-д заасан ажил, албан тушаалаас чөлөөлөгдөхийг шаардах нь хуульчийн эрх зүйн байдалд сөрөг үр дагавар бий болгож байна.

Энэхүү асуудлаар Үндсэн хуулийн цэц 2022 оны 02 дугаар дүгнэлтийг гаргасан байдаг. Уг дүгнэлтээр тухайн заалт нь Үндсэн хуулийн хууль зөрчөөгүй гэж дүгнэсэн боловч үндэслэх хэсэгтээ Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт Үндсэн хуулийн хуульд заасан ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгохыг хязгаарласан байх магадлалтай гэж хүлээн зөвшөөрсөн байдаг.

Мөн түүнчлэн итгэмжлэгдсэн төлөөлөгч Мөнх-Оргил гишүүний зүгээс Улсын Их Хурал энэ өөрөө засах боломжтой юм гэдгийг бас дурдсан байдаг.

Иймд энэхүү хуулийн төслийг дэмжиж өгнө үү. Хэлэлцэх эсэхийг дэмжиж өгнө үү.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүнд баярлалаа. Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Алга байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалын баримтлалтай холбогдуулан гишүүд үг хэлэх гишүүд байна уу?

Энхбаяр гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Уянгахишиг гишүүнээс санаачилсан Өмгөөллийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байна. Их нарийн хүний эрхийн зөрчлийг их олж харсан байна. Үнэхээр бид хүн шалгалтдаа тэнцэх эсэх нь мэдэгдэхгүй зүгээр оръё гэж байхад нь чи заавал ажлаа өгч байж шалгалтад ор гэдэг ийм шалгуурыг хуульчдад өөрсдөд нь ингээд тавьчихсан

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байгаа асуудлыг бас Уянгахишиг гишүүн сайн олж хараад энэ хуулийн өөрчлөлтийг санаачилж байгаад би Байнгын хорооныхоо гишүүдэд 100 хувийн саналаар дэмжье гэсэн уриалгыг хэлж байна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д заасны дагуу санал хураалт явуулъя.

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Сайнзориг гишүүн дэмжсэн байна. Нара гишүүн дэмжсэн үү? Нара гишүүнийх орчихсон байгаа юм байна тийм үү? Сайнзориг гишүүнийг тэгэхээр дэмжсэнээр бүртгэж аваарай.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Нара гишүүн унших уу?

Нара гишүүн, эмэгтэй хүний юуг Нара гишүүн унших уу? За яах вэ зүгээр.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

18.37 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР